



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



Гүйцэтгэлийн аудитын тайлан

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ЭДИЙН
ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР ДҮНГ
ТООЦООГҮЙ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ
БҮРЭН ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
БАТАЛЖ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР
АШГИЙГ БУУРУУЛЖ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ**

АУДИТЫН КОД: ГАГ-2019/01-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор Б.Мөнх-Очир
Утас: 263755, цахим хаяг: munkh-ochirb@audit.gov.mn
Аудитын менежер Б.Саруул
Утас: 261805, цахим хаяг: saruulb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Долгорсүрэн
Утас: 262451, цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Аудитор Б.Хаш-Эрдэнэ
Утас: 262451, цахим хаяг: khasherdeneb@audit.gov.mn
Аудитор Э.Уянга
Утас: 262451, цахим хаяг: uyangae@audit.gov.mn
Аудитор Ү.Төгсжаргал
Утас: 262451, цахим хаяг: tugsjargalu@audit.gov.mn
Аудитор Ш.Наранбаатар
Утас: 262451, цахим хаяг: baranbaatarsh@audit.gov.mn
Аудитор Б.Алтангэрэл
Утас: 262451, цахим хаяг: altangerelb@audit.gov.mn

Улаанбаатар хот
2019 он



2019 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлагыг 2 дугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж, тайланд тусгагдсан төлбөрийн акт, албан шаардлага болон зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /Б.Мөнх-Очир/-т үүрэг болгосугай.

4. Аудитын тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /Б.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Б.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_Khuregi\Tushaah\2019\A_Tushaah\0507\GA-G4 Docx

070585



АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Зураг, дүрслэлийн жагсаалт	4
Хүснэгтийн жагсаалт.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	6
Ерөнхий мэдээлэл	8
БҮЛЭГ 1. НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 45.5 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛИЙГ ХАНГААГҮЙ НЬ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР АШГИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.....	12
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон баримт бичиг хоорондоо уялдахгүй байна	12
Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй 341 төсөл, арга хэмжээг баталсан байна	14
БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ 72.6 ХУВЬТАЙ БАЙНА	17
Засгийн газраас 2018 оны худалдан авах ажиллагааг бүрэн хэмжээнд цахим систем ашиглан зохион байгуулахыг даалгасан боловч хэрэгжилт 49.0 хувьтай байна	17
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 72.6 хувьтай байна.....	23
Барилга угсралтын ажил гүйцэтгэгч зарим компани гэрээний үүргээ биелүүлээгүй, зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэхгүй байна	24
Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна	25
Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хангалтгүй байна	30
БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ БАЙНА	31
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийгэмд үзүүлэх үр нөлөө, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй байна	31
Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна	32
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна	34
ДҮГНЭЛТ	35
ЗӨВЛӨМЖ	37
Сангийн яамнаас ирүүлсэн санал	39
Ирүүлсэн саналд өгөх тайлбар	41
ХАВСРАЛТУУД	42
Хавсралт 1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар төсөвт өртөг нэмэгдсэн шилжих төсөл, арга хэмжээний судалгаа	42
Хавсралт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 онд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний судалгаа	43
Хавсралт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний судалгаа.....	46
Хавсралт 4. Он дамжин хэрэгжсэн ТАХ-ний батлагдсан төсөвт өртгийг 2018 оны төсөвт өртгийн өнөөгийн үнэ цэнэтэй харьцуулсан судалгаа	49
Хавсралт 5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын төсөвт өртөгт орсон өөрчлөлтийн судалгаа	50



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
БЗОСК	Барилга захиалагч, орон сууцны корпораци
БОАЖС	Байгаль орчин аялал, жуулчлалын сайд
БНБД	Барилгын норм ба дүрэм
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
ИЗБНХ	Инженер зохион бүтээгчдийн нэгдсэн холбоо
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУЕТГ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
МУЕП	Монгол Улсын Ерөнхий прокурор
МУИХТГ	Монгол Улсын Их Хурлын Тамгын газар
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗҮЭГ	Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХС	Эрчим хүчний сайд

Зураг, дүрслэлийн жагсаалт

Дугаар	Нэр
Дүрслэл 1	ДНБ-нд нэгдсэн төсвийн хөрөнгийн зарлагын эзлэх хувь
Дүрслэл 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа
Дүрслэл 3	Худалдан авах ажиллагааны үнэлгээ



Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Нэр
Хүснэгт 1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбараар ангилсан судалгаа
Хүснэгт 2	Улсын төсвийн 2017, 2018 оны хөрөнгө оруулалт
Хүснэгт 3	Төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл
Хүснэгт 4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа
Хүснэгт 5	Улсын төсвийн 2017, 2018 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт
Хүснэгт 6	Шинээр эхлүүлэх ТАХ-ний зураг төсвийн баталгаажсан байдал
Хүснэгт 7	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын илрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл
Хүснэгт 8	Үнэлгээний хороо байгуулсан хугацаа
Хүснэгт 9	Төсвийн ерөнхийлөн захирагчдын худалдан авах ажиллагааны үнэлгээ
Хүснэгт 10	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 онд хэрэгжээгүй ТАХ-ний судалгаа
Хүснэгт 11	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр баригдсан дотуур байрны хүчин чадал, хүүхдийн тооны судалгаа
Хүснэгт 12	Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн худалдан авалтын судалгаа



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2018 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5¹-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

“Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгжилт, үр дүнтэй эсэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцсон эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан 22 ТЕЗ-ийн багцад хамаарах 749 ТАХ-ний төлөвлөлт, хэрэгжилтийг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчид, түүний харьяа байгууллагууд, Сангийн яам, ТӨБЗГ, Барилгын хөгжлийн төв, эрх шилжсэн ТАХ-ний тухайд аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар, техник хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагууд, зарим ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хамрууллаа.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар батлагдсан “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 299.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний хэрэгжилтэд ҮАГ-аас УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын дагуу тус бүрд нь дүгнэлт гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх тул энэ аудитад хамруулаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнууд, шинжээчидтэй ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах арга зүйг ашиглан ТЕЗ нарын худалдан авах болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, мэдээ, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

ТЕЗ нараас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтэд орон нутаг дахь Төрийн аудитын газрууд аудит хийлээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, 2018 онд ашиглалтад оруулсан болон ашиглалтад ороход бэлэн болсон 25 барилгад хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулахаар “Ата бьюлдинг” ХХК, Вест коммерс” ХХК,

¹ улсын төсвийн хөрөнгө оруулалт, түүний үр дүнд аудит хийх.



“Халтар асга” ХХК, “Барилгын төсөвчдийн холбоо” ТББ-тай гэрээ байгуулан хамтарч ажиллалаа.

Аудитад ашигласан шалгуур, үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.
Үүнд:

- Барилгын тухай хууль,
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Засгийн газрын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 386 дугаар тогтоол,
- Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт”,
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”,
- Сангийн сайдын 2017 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 273 дугаар тушаал,
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт.


Хүндрэл бэрхшээл:

Аудитад шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалтын зураг төсөл, худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилттэй холбоотой судалгааг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж ирүүлээгүйгээс улсын хэмжээний худалдан авах ажиллагаа, гүйцэтгэлийн үр дүнг нэгтгэх боломжгүй байна.

Аудитын дүн:

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 84.6 тэрбум төгрөгийн 548 алдаа, зөрчлийг илрүүлж, 12 зөрчилд хамаарах 1.3 тэрбум төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 131 зөрчлийг арилгуулахаар 28.7 тэрбум төгрөгийн 15 албан шаардлага, 54.1 тэрбум төгрөгийн 403 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч, 0.5 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар тус тус хүргүүлэв.

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын жагсаалтаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт гүйцэтгэлд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас хийсэн аудитаар 43.5 тэрбум төгрөгийн 332 алдаа, зөрчлийг илрүүлж, 12 зөрчилд хамаарах 0.6 тэрбум төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоож, 160 зөрчлийг арилгуулахаар 20.8 тэрбум төгрөгийн 58 албан шаардлага, 22.6 тэрбум төгрөгийн 160 зөрчлийг арилгуулах зөвлөмж өгөгдсөн байна.



Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8²-д заасны дагуу Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 140 дүгээр тогтоолоор “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон түүний шалгуур үзүүлэлт”-ийг баталсан байна.

Мөн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрт тусгагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-г төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн баримт бичиг” тодорхойлсон байна.

УИХ-аас Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлахаас өмнө Засгийн газар Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8³-д заасан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг батлаагүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэлд хөрөнгийн зардлын хэмжээг 1,928.5 тэрбум төгрөг буюу ДНБ-д эзлэх хэмжээг 6.3 хувь байхаар баталснаас урьдчилсан гүйцэтгэлээр 1,607.8 тэрбум төгрөг буюу ДНБ-д эзлэх хэмжээ 5.0 хувь болсон нь төсвийн хүрээний мэдэгдлээс 1.3 пунктээр бага байна.

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
ДНБ, оны үнээр (Tugriks)	19,000.0	22,000.0	23,000.0	24,000.0	27,000.0	32,000.0
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал (Tugriks)	2,000.0	2,000.0	2,000.0	2,500.0	2,000.0	2,000.0
Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (Tugriks)	6,000.0	7,000.0	7,000.0	9,500.0	9,000.0	9,500.0
Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх буй бодит хувь (%)	35.0	35.0	33.0	40.0	35.0	28.0
ДНБ, өсөлтийн хувь (%)	11.0	8.0	3.0	3.0	6.0	6.0
Хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх буй бодит хувь (%)	10.0	10.0	8.0	12.0	8.0	8.0

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын бодлого нь УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020

³ Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгоно.



оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.2-т “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно”, 3.2.3-т “Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлж бүхий сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ”, 3.1-т “хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх” гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор шинээр сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга барих зэрэг нийгмийн салбарын ТАХ-г хэрэгжүүлэхэд түлхүү чиглэгдсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг салбараар ангилж үзэхэд 2018 онд боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, хөдөлмөр нийгмийн хамгаалал, төрийн төв байгууллагуудын хөрөнгө оруулалт өмнөх оноос 1.2-1.5 дахин нэмэгдэж, дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт 0.7 дахин буурчээ.

Хүснэгт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын салбараар ангилсан судалгаа /тэрбум төгрөг/

Салбарын ангилал	2015 он	2016 он	2017 он	2018 он	
				Дүн	Эзлэх хувь
Дэд бүтэц	52.7	57.9	331	198.8	29.1
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	91.7	100.9	104.3	262.8	38.5
Эрүүл мэнд	38.9	40.8	61.7	60.8	8.9
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	14.6	23.9	7.8	17.3	2.5
Төрийн төв байгууллагууд	11.8	12.8	27.4	59.4	8.7
Хууль сахиулах, батлан хамгаалах	33.5	8.5	39.2	42	6.1
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	2	1.5	27.8	38.2	5.6
Хүнд үйлдвэр	1.6	57.9	2.8	4	0.6
Дүн	246.8	246.4	602.1	683.3	100.0

Эх сурвалж: Сангийн яам, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 оны урьдчилсан гүйцэтгэл

Тайлант онд нийгмийн салбарт 49.9 хувь буюу 340.9 тэрбум, дэд бүтцийн салбарт 29.7 хувь буюу 202.8 тэрбум, бусад салбарт 20.4 хувь буюу 139.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр хуваарилсан байна.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар 22 ТЕЗ-ийн багцад батлагдсан 2,159.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 749 ТАХ-нд 683.3 тэрбум төгрөг, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 5 төслийн эргэн төлөлтөд 82.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ТАХ-ний тоо 2 дахин, санхүүжих дүн 81.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Хүснэгт 2. Улсын төсвийн 2017, 2018 оны хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/

Санхүүжилтийн эх үүсвэр	2017 онд				2018 онд				Өсөлт (+), бууралт (-) 2018/2017
	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	Санхүүжилт Мөнгөн дүн	Хувь	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	Санхүүжилт Мөнгөн дүн	Хувь	
Улсын төсөв	373	602.1	539.6	89.6	749	683.3	580.4	84.9	81.2
Концессын эргэн төлөлт	15	177.7	176.2	99.1	5	82.9	79.0	95.3	(94.8)
Нийт дүн	388	779.8	715.8	91.8	754	766.2	659.4	86.1	(13.6)

Эх сурвалж: Төсвийн тухай хууль, Сангийн яам

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-нд 580.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 84.9 хувь, концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 5 төслийн эргэн төлөлтөд 79.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 95.3 хувь, нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг Сангийн яамнаас 86.1 хувь гэж тайлагнасан байна.



Хүснэгт 3. Төсөл арга хэмжээний санхүүжилт, ажлын гүйцэтгэл /сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Санхүүжилтийн гүйцэтгэл		Үүнээс			
				Урьдчилгаа төлбөрийн баталгаа, бусад хэлбэрээр олгосон санхүүжилт		Бодит ажлын гүйцэтгэл		Дүн	Хувь
				Дүн	Хувь	Дүн	Хувь		
МУЕТГ-ын дарга	3	770.7	770.7	754.3	97.9			754.3	97.9
МУИХ-ын дарга	1	1,913.3	1,913.3	1,701.4	88.9			1,701.4	88.9
МУЕС	8	5,685.3	3,762.8	2,709.9	72.0			2,709.9	72.0
МУШС	12	12,695.2	6,006.4	5,843.3	97.3	125.0	2.1	5,718.3	95.2
ЗГХЭГ-ын дарга	32	23,920.9	11,881.8	10,459.8	88.0	580.0	4.9	9,879.8	83.1
БОАЖС	13	12,789.5	10,389.5	10,178.7	98.0	4,286.4	41.3	5,892.3	56.7
ГХС	3	1,800.0	1,800.0	1,800.0	100.0			1,800.0	100.0
СС	14	78,098.1	32,810.0	20,786.3	63.4			20,786.3	63.4
ХЗДХС	40	59,590.9	37,390.0	37,204.3	99.5			37,204.3	99.5
ХНХС	25	36,723.3	17,340.0	16,852.6	97.2	1,650.9	9.5	15,201.7	87.7
БХС	4	19,417.4	3,599.5	3,334.8	92.6			3,334.8	92.6
БХБС	78	430,501.9	80,338.4	67,408.4	83.9	10,608.2	13.2	56,800.2	70.7
БСШУСС	325	739,860.0	262,817.6	222,404.6	84.6	40,658.6	15.5	181,746.0	69.1
ЗТХС	64	342,951.3	80,796.9	68,408.6	84.7	7,057.0	8.7	61,351.6	76.0
УУХУС	5	3,980.0	3,980.0	3,623.1	91.0	526.9	13.2	3,096.2	77.8
ХХААХУС	32	41,521.3	27,818.5	22,154.1	79.6	2,018.8	7.3	20,135.3	72.3
ЭХС	20	151,489.7	37,661.9	36,905.0	98.0	1,809.0	4.8	35,096.0	93.2
ЭМС	63	193,319.5	60,754.8	46,422.7	76.4	14,554.9	24.0	31,867.8	52.4
АТГ-ын дарга	1	195.6	195.6	195.6	100.0			195.6	100.0
ҮХЦ-ийн дарга	1	340.0	340.0	339.4	99.8			339.4	99.8
МУЕП	4	1,562.0	452.0	450.8	99.7			450.8	99.7
МУЕА	1	500.0	500.0	498.0	99.6			498.0	99.6
Нийт	749	2,159,625.8	683,319.8	580,435.7	84.9	83,875.7	12.3	496,560.0	72.6

Эх сурвалж: Үндэсний аудитын газар, Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд төрийн үйлчилгээний барилга 6, 3968 суудалтай 7 сургууль, 170 ортой 5 дотуур байр, 1580 ортой 13 цэцэрлэг, 60 ортой 5 эмнэлэг, 1050 суудалтай 2 соёлын төв, 4199.7 м.кв талбайтай 1 спорт заал, аврах гал унтраах ангийн 3 барилга, 154 ширхэг худаг, 10 сумын 150 км 0.4-15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэл, 11 халаалтын зуух, 6.2 км дулааны шугам, сүлжээний өргөтгөл, 23.7 км кабель шугам, 248.7 км хатуу хучилттай автозам, 793.4 урт/метр гүүр, гүүрний байгууламжийг ашиглалтад хүлээн авчээ.

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн үр дүнг өмнөх 5 жилийн дундажтай харьцуулахад бүх салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан барилга, байгууламжийн тоо буурсан байна.

Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад орсон барилга, байгууламжийн судалгаа /хүчин чадал/


Барилга, байгууламжийн ангилал	Хэмжих нэгж	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	Өмнөх 5 жилийн дунджаас өссөн, буурсан
Хатуу хучилттай авто зам	км	336	435	1171.9	176.6	844.8	135.5	(457.4)
Төмөр бетон гүүр	у/м	320	1259	586.2	289.9	509.6	202.4	(390.5)
ЦДАШ	км	636	472	562.4	65.3	-	150.0	(197.1)
Хүүхдийн цэцэрлэг	орны тоо	2150	3125	1820	2170	4295	1580	(1132)
Ерөнхий боловсролын сургууль	суудлын тоо	6248	11183	7280	8008	15070	3968	(5589.8)
Дотуур байр	орны тоо	1430	1000	1270	620	900	170	(874)
Соёлын төв	суудлын тоо	1250	2000	2320	1400	-	1050	(344)
Хүн эмнэлэг	орны тоо	270	445	460	545	110	60	(306)

Эх сурвалж: Үндэсний аудитын газар

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл 2018 онд сүүлийн 5 жилийн дунджаас 0.4 хувиар илүү байна.



Дүрслэл 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэлийн судалгаа, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар 749 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,104.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 527.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 635 ТАХ нь шинэ, 1,055.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 156.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 114 ТАХ нь шилжих ангилалд батлагдсан байна.



БҮЛЭГ 1. НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 45.5 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛИЙГ ХАНГААГҮЙ НЬ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР АШГИЙГ БУУРУУЛЖ БАЙНА

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон баримт бичиг хоорондоо уялдахгүй байна

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т 2018 онд шилжин хэрэгжих 12 төсөл, хөтөлбөрт 123.7 тэрбум, шинээр хэрэгжүүлэх 8 төсөл, хөтөлбөрт 186.3 тэрбум, нийт 20 төсөл, хөтөлбөрт 309.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгагджээ.

1.2 Энэ нь Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдсаны дараа тус хөтөлбөр батлагдсантай холбоотой байна.

1.3 УИХ-ын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 47 ТАХ-г 677.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгагдсанаас Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд 468.2 тэрбум төгрөгөөр санхүүжих 19 ТАХ нь батлагдаагүй байна.

1.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1⁴-т заасан хугацаанд ирүүлсэн ТЕЗ нарын саналд үндэслэн 2018 оны төсвийн хязгаарыг боловсруулж, мөн хуулийн 8.3.3⁵-т заасны дагуу Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 188 дугаар тогтоолоор нийт 15 ТЕЗ нарын хөрөнгийн зардлын хязгаарыг 563.9 тэрбум төгрөгөөр баталжээ.

1.5 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд дээрх төсвийн хязгаарт тусгагдаагүй 6.0 тэрбум, төсвийн хязгаараас давуулж 269.4 тэрбум төгрөгийн хөрөнгийн зардлыг баталсан байна. Үүнд:

Төсвийн хязгаарт хөрөнгийн зардал тусгагдаагүй:

- МУЕТГ-ын даргын багцад 770.7 сая,
- УИХ-ын даргын багцад 1,913.3 сая,
- ҮХЦ-ийн даргын багцад 340.0 сая,
- МУЕП-ын багцад 452.0 сая,
- ГХС-ын багцад 1,800.0 сая,
- МУЕА-ын багцад 500.0 сая,
- АТГ-ын даргад 195.6 сая, нийт 5,971.6 сая төгрөг.

Төсвийн хязгаараас давуулан:

- ЗГХЭГ-ын даргын багцад 8,784.9 сая,
- ХЗДХС-ын багцад 20,388.2 сая,
- БОАЖС-ын багцад 61.5 сая,
- БСШУСС-ын багцад 186,220.5 сая,
- ХНХС-ын багцад 11,491.0 сая,
- ЭХС-ын багцад 10,994.3 сая,
- БХБС-ын багцад 31,435.3 сая, нийт 269,375.7 сая төгрөг.

1.6 Засгийн газраас 2,075.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 690 ТАХ-г 625.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөн УИХ-д өргөн барьсан боловч Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг батлахдаа 84.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 59 ТАХ-г нэмж, санхүүжилтийн хэмжээг 58.0 тэрбум төгрөгөөр бууруулжээ. Үүнд:

- 86.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 48.2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 63 ТАХ шинээр нэмэгдсэн,
- 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2.1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 ТАХ хасагдсан,

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлэх.

⁵ Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах.



- 10 ТАХ-ний санхүүжих дүнг 6.8 тэрбум төгрөгөөр бууруулсан,
- 47 ТАХ-ний санхүүжих дүн 18.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

1.7 Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11-т заасан улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг тайлант хугацаанд баталж мөрдөөгүй, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлээгүй байна.

1.8 Энэ нь Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй орхигдож, чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээ батлагдах эрсдэлийг үүсгэсэн байна. Тухайлбал,

- БХБС-ын багцад гудамж, талбайн гэрэлтүүлэг, тохижилт, хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн орон сууцны дээврийн засвар зэрэг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх боломжтой 17,093.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10,117.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 32 төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн ч бодлогын баримт бичигт тусгагдсан Улаанбаатар хотын 200 байршилд инженерийн шугам сүлжээний 750.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажил орхигдсон,
- ХХААХҮС-ын чиг үүрэгт хамааралтгүй 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ухаалаг худгийн барилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15-р хороо/ 1,000.0 сая төгрөгийн өртөгтэй зөөврийн болон гүний худаг /Сонгинохайрхан дүүргийн 7, 8, 9, 24, 25 дугаар хороо/ төслийг хэрэгжүүлэхээр баталсан.

1.9 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г ангиллаар авч үзвэл,

Хүснэгт 5. Улсын төсвийн 2017, 2018 оны хөрөнгө оруулалтын харьцуулалт /тэрбум төгрөг/

Хөрөнгө оруулалтын ангилал		Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хууль			Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль			Зөрүү нэмэгдсэн +/-, хасагдсан -/-		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Хөрөнгө оруулалт	шинэ	12	104.6	96.6	456	928.3	385.2	444	823.7	288.6
	шилжих	321	2,200.0	385.2	112	1,039.4	150.7	(209)	(1,160.6)	(234.5)
Их засвар	шинэ	5	22.3	21.5	106	97.9	69.7	101	75.6	48.2
	шилжих	6	77.7	38.4	1	7.5	2.5	(5)	(70.2)	(35.9)
Тоног төхөөрөмж	шинэ	13	44.4	41.3	68	59.3	54.7	55	14.9	13.4
	шилжих	6	45.7	18.2	1	8.1	3.1	(5)	(37.6)	(15.1)
ТЭЗҮ	шинэ	-	-	-	5	19.1	17.4	5	19.1	17.4
	шилжих	10	8.7	0.8	-	-	-	(10)	(8.7)	(0.8)
ДҮН		373	2,503.4	602.0	749	2,159.6	683.3	376	(343.8)	81.3

Эх сурвалж: Монгол Улсын 2017, 2018 оны төсвийн тухай хууль

1.10 Хуульд батлагдсан ТАХ-ний 84.8 хувь буюу 1,104.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 635 ТАХ шинээр хэрэгжих, 15.2 хувь буюу 1,055.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 114 ТАХ шилжих арга хэмжээ буюу өмнөх онтой харьцуулахад шинээр хэрэгжүүлэх ТАХ 21.2 дахин нэмэгдэж, харин шилжих арга хэмжээ 3 дахин буурсан байна.

1.11 Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад шилжих ТАХ-г орхигдуулж баталснаас он дамжих барилгын тоо нэмэгдэх, гүйцэтгэл удаашрах эрсдэлийг дагуулж, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Тухайлбал,

БСШУСС-ын багцад:

- 2012 оноос хэрэгжиж эхэлсэн 4,186.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2017 онд 1,602.7 сая төгрөгийн санхүүжилт авсан Булган аймгийн Булган сумын 640 суудалтай сургуулийн барилга,
- 2015 онд хэрэгжиж эхэлсэн 1,123.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2017 онд 607.3 сая төгрөгийн санхүүжилт авсан Өвөрхангай аймгийн Хужирт сумын 75 ортой цэцэрлэгийн барилга,

ЭХС-ын багцад:

- 2014 онд хэрэгжиж эхэлсэн 16,987.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2017 онд 907.6 сая төгрөгийн санхүүжилт авсан ДЦС 4-өөс У-18 хүртэлх /Москва хорооллын урд тал хүртэл/ 4.2 км, Ф800 голчтой дулааны шугамын барилга усралтын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/,

ЗТХС-ын багцад:



- 2014 онд эхэлсэн 7,888.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2017 онд 702.1 сая төгрөгийн санхүүжилт авсан Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг Москва хорооллын арын далангаар явуулж, Өнөр хорооллын 33 дугаар байрны арын замтай холбох 1 км автозамын барилгын ажил зэрэг жишээг дурдаж болохоор байна.

Төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй 341 төсөл, арга хэмжээг баталсан байна

1.12 ТЕЗ нар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶ -т заасныг хэрэгжүүлдэггүйгээс улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар баталгаажсан зураг, төсөвтэй байх шаардлага хангаагүй 341 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр батлуулснаас 2019 оны 6 дугаар сарын байдлаар 76 ТАХ-ний зураг, төсөв боловсруулагдаж, баталгаажаагүй байна.

Хүснэгт 6. Шинээр эхлүүлэх ТАХ-ний зураг төсвийн баталгаажсан байдал /тоо, эзлэх хувь/

Д/д	ТЕЗ-ийн нэр	Шинээр эхлүүлэх зураг, төсөв шаардлагатай ТАХ-ний тоо	Үүнээс,		Хууль баталсны дараа зураг төсвийг батлуулсан ТАХ-ний		Зураг төсвөө батлуулаагүй ТАХ-ний	
			Хуульд тусгахдаа зураг, төсвийг нь батлуулсан ТАХ-ний					
			Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	МУЕС	7	-	0.0	7	1.7	-	0.0
2	МУШС	4	4	1.0	-	0.0	-	0.0
3	ЗГХЭГ-ын дарга	19	1	0.2	17	4.0	1	0.2
4	БОАЖС	12	2	0.4	10	2.4	-	0.0
5	СС	7	4	1.0	3	0.7	-	0.0
6	ХЗДХС	13	12	2.8	1	0.2	-	0.0
7	БХС	1	-	0.0	1	0.2	-	0.0
8	БХБС	36	12	2.8	19	4.5	5	1.2
9	БСШУСС	228	30	7.1	142	33.6	56	13.3
10	ЗТХС	35	5	1.2	28	6.6	2	0.4
11	ХХААХҮС	17	5	1.2	11	2.6	1	0.2
12	ЭХС	14	4	1.0	10	2.4	-	0.0
13	ЭМС	29	3	0.7	15	3.5	11	2.6
14	МУЕП	1	-	0.0	1	0.2	-	0.0
Нийт		423	82	19.4	265	62.6	76	18.0

Эх сурвалж: УАГ

1.13 Улсын 2018 оны төсвийн тухай хуульд он дамжин хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын 16 ТАХ-ний төсөвт өртөг 28.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 5 ТАХ-ний төсөвт өртөг 1.8 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу)

1.14 Түүнчлэн 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан зарим төслийн төсөвт өртөг 2019 оны Төсвийн тухай хуульд батлагдахдаа нэмэгдсэн байна. Тухайлбал,

БСШУСС-ын багцад:

- Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 62 дугаар сургууль/-ийн 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын өртөг 2019 онд 6,515.6 сая,
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 23 дугаар сургууль/-ийн ажлын төсөвт өртөг 2018 онд 1,500.0 сая, 2019 онд 2,190.8 сая,
- Сургуулийн барилга буулгаж шинээр барих, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр сургууль/ ажлын өртөг 2018 онд 3,266.8 сая, 2019 онд 5,027.8 сая,
- Сургуулийн барилгын өргөтгөл, 450 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 50 дугаар сургууль/-ийн ажлын төсөвт өртөг 2018 онд 1,500.0 сая, 2019 онд 1,806.2 сая,
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 62 дугаар цэцэрлэг/ төслийн төсөвт өртөг 2018 онд 1,500.0 сая, 2019 онд 2,005.8 сая,
- Сумын төвийн төмөр бетон гүүр /Өвөрхангай, Хужирт сум/ барих ажлын төсөвт өртөг 2018 онд 400.0 сая, 2019 онд 770.0 сая,
- Онгийн голын модон гүүр /Өвөрхангай, Зүүнбаян-улаан сум/ барих ажлын төсөвт өртөг 2018 онд 120.0 сая, 2019 онд 350.0 сая,

ЭМС-ын багцад:

⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



- Дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо, Хайлааст салбар/-ийн ажлын төсөвт өртөг 2018 онд 4,200.0 сая, 2019 онд 10,000.0 сая,
- Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/-ийн ажлын төсөвт өртөг 2018 онд 2,800.0 сая, 2019 онд 8,250.5 сая,

БХБС-ын багц:

- Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, 1.8 км /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21, 27 дугаар хороо/ ажлын төсөвт өртөг 2018 онд 3,500.0 сая, 2019 онд 4,391.4 сая төгрөг болж тус тус нэмэгдсэн байна.

1.15 Баталгаажсан зураг, төсөвгүй барилга, байгууламжийн төсөвт өртгийг Монгол Улсын төсвийн тухай хуульд тойм тоогоор батлуулдаг нь зураг, төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болжээ.

1.16 Зарим барилга, байгууламжийн нэмэлт ажлын зураг, төсвийг хууль батлагдахаас өмнө магадлал хийлгэж баталгаажуулалгүйгээр төсөвт өртгийг нийт 3,872.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж батлуулсан байна. Тухайлбал,

БХС-ын багц:

- “Бага баян” ТӨҮГ-ын автозамын ажлын дуусгал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төслийн төсөвт өртөг 770.0 сая,

БСШУСС-ын багц:

- Спорт заал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 61 дүгээр сургууль/-ны барилгын төсөвт өртөг 549.2 сая,
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/ -ын төсөвт өртөг 189.8 сая ,
- Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/ -ын төсөвт өртөг 500.1 сая ,

ЭМС-ын багц:

- Сумын эрүүл мэндийн төв, 14 ор /Баянхонгор, Баянцагаан сум/-ийн төсөвт өртөг 363.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

1.17 Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.3-т “эдийн засгийн ангиллаар”, мөн хуулийн 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 2.1.1⁷-т заасныг баримтлалгүйгээр барилга, байгууламжийн ангилалд их засвар, тоног төхөөрөмж авах ажлыг нэгтгэн төлөвлөж батлуулжээ. Тухайлбал,

ЭМС-ын багц:

- “Бельгийн Вант Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах төслийн монголын талын хөрөнгө” /Ховд, Жаргалант сум/-ийн 8,700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах ажлыг барилга, байгууламжийн ангилалд,
- “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга” /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/-ын төсөвт өртгийн 10,383.8 сая төгрөг нь барилга барихад, 8,355.4 сая төгрөг нь тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулагдахаар байхад нэгтгэн барилга, байгууламжийн ангилалд,

ХХААХҮС-ын багц:

- “Атрын III аян, Мах, сүүний анхдугаар аяныг үргэлжлүүлэх хөрөнгө оруулалт”-ын 13,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд улсын хэмжээнд хийгдэх их засварын 751.2 сая, тоног төхөөрөмж худалдан авах 337.5 сая төгрөгийн ажлыг нэгтгэж, барилга, байгууламжийн ангиллаар батлуулсан байна.

1.18 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 635 ТАХ-ний санхүүжих дүнг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁸-д заасныг баримтлахгүйгээр 180 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаанд ногдох санхүүжилтийн дүнгээс багаар батлуулж

⁷ “Барилга байгууламж” гэж “Барилгын тухай” хууль /шинэчилсэн найруулга/-ийн 4.1.1-т зааснаар барилгын норм, дүрмийн дагуу боловсруулж, магадлал хийгдсэн зураг төслөөр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн барьсан орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, зам гүүр, ус, нефтийн барилга, ус суваг, далан, хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг.

⁸ Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын ТАХ-ний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.



байгаа нь тэдгээр арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэлийг бий болгож байна.

1.19 Иймд дээрх ТАХ-ний үлдэгдэл санхүүжилтийг дараа оны төсвийн тухай хуульд төлөвлөхдөө нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсгийг ТАХ-ний хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тусгаж байх шаардлагатай юм.

1.20 Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд (хуучин нэрээр)-ын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан БНБД 81-95-12 “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 4.28-д заасныг зөрчин БСШУСС-ын багцын 2 барилга, байгууламжийн төсөвт өртөгт материалын үнийг зах зээлийн үнээс өндрөөр тооцсоноос төсөвт өртөг 128.3 сая төгрөгөөр үндэслэлгүйгээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Сургуулийн барилга 960 суудалтай /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний өрлөг шавардлагын зуурмагийг бэлэн зуурмагаар, орон нутгаас бетон зуурмаг, элс, хайрга, ус, тээвэрлэх зайн хэмжээг буруу тооцож төсөвт өртгийг 55.1 сая,
- Соёлын төвийн барилга 400 суудалтай /Өвөрхангай, Уянга сум/ ТАХ-ний бетон зуурмагийг бэлэн зуурмаг авахаар тооцсоноос шалтгаалж 73.2 сая төгрөгөөр тус тус төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна.

1.21 Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд (хуучин нэрээр)-ын 2010 оны 107 дугаар тушаалаар батлагдсан Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалтын БНБД 12-01-09-ийн 5.1-т “Барилгын үйлдвэрлэлийн бэлтгэл ажилд дараах ажлууд хамаарна, ... газрын зөвшөөрөл авах, баригдах барилга байгууламжийг холбох техникийн нөхцөл авах” заасныг мөрдөлгүйгээр бэлтгэл ажил хангагдаагүй төсөлд санхүүжилт олгохоор төлөвлөснөөс батлагдсан хөрөнгө ашиглагдаагүй байна. Тухайлбал,

БХБС-ын багац:

- Монголын үндэсний олон нийтийн радио телевиз орчмын хорооллын 6 хэсгийн 6 ширхэг ус, дулаан дамжуулах төвийн барилга, гадна цахилгаан хангамжийн зураг төсөв, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ТАХ-а 2014-2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж, “Би Ти Икс” ХХК-тай гэрээ байгуулсан боловч 4 ус дулаан дамжуулах төвийн барилга барих газрын асуудал шийдэгдээгүйн улмаас ажлын гүйцэтгэл 30 хувьтай,
- Дулаан хангамжийн эх үүсвэр, хатуу түлшний халаалтын тогоо 5 ширхэг, ялтсан дулаан солилцуур 3 иж бүрдлийн барилга угсралтын ажил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ ТАХ-ний газар чөлөөлөлтийн асуудал шийдэгдээгүйн улмаас 2018 онд ажил хийгдээгүй, ажлын гүйцэтгэл 75.0 хувьтай,
- Дулааны шугам сүлжээний Ø 32/200 мм-ийн голчтой 3539 метр шугамын барилга угсралтын ажил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ ТАХ-ний газар чөлөөлөлтийн асуудал шийдэгдээгүйн улмаас 2018 онд ажил хийгдээгүй, ажлын гүйцэтгэл 75.0 хувьтай,
- Дэнжийн 1000 орчмын инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ ТАХ-ний газар чөлөөлөлтийн асуудал шийдэгдээгүйн улмаас 2018 онд хэрэгжээгүй,
- Нэхмэлийн шар байр орчмын дахин барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо/ ТАХ-ний газар чөлөөлөлт, техникийн нөхцөлийг баталгаажуулах асуудал шийдэгдээгүйн улмаас 2018 онд ажил хийгдээгүй, ажлын гүйцэтгэл 21.0 хувьтай,

ЗГХЭГ-ын даргын багц:

- Төрийн үйлчилгээний цогцолборын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо/-ын газрын зөвшөөрөл олгогдоогүйн улмаас 2018 онд хэрэгжээгүй,

БСШУСС-ын багц:

- Сургуулийн барилга, 920 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо/ ТАХ-ний газрын зөвшөөрөл олгогдоогүйн улмаас 2018 онд хэрэгжээгүй.

1.22 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсвийн тухай хуульд заасан зарчим, шаардлага, үндэслэлийг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.



БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ 72.6 ХУВЬТАЙ БАЙНА

Засгийн газраас 2018 оны худалдан авах ажиллагааг бүрэн хэмжээнд цахим систем ашиглан зохион байгуулахыг даалгасан боловч хэрэгжилт 49.0 хувьтай байна

2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд санхүүжүүлэх ТАХ, барилга байгууламжийн жагсаалтад батлагдсан шинээр хэрэгжих 1,104.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 527.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 635 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 1055 худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

2.2 Нийт худалдан авах ажиллагааны 859 буюу 81.4 хувийг нь нээлттэй тендер шалгаруулалтын, 111 буюу 10.5 хувийг нь харьцуулалтын, 70 буюу 6.6 хувийг нь шууд гэрээ байгуулах, 15 буюу 1.4 хувийг нь хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг хэрэглэсэн байна.

2.3 Засгийн газрын 2017 оны 17 дугаар хуралдааны тэмдэглэлээр 2018 оны худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулах чиглэл өгсөн боловч ТЕЗ нарын 2018 оны худалдан авах ажиллагааны тайланд үндэслэн тооцож үзэхэд нийт 2568 тендерийг цахим системээр гүйцэтгэхээр төлөвлөснөөс 1302 тендерийг зохион байгуулж, гүйцэтгэл 49.0 хувьтай байна.

2.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор тайлант онд нийт 31.6 тэрбум төгрөгийн 141 гэрээг тус системд бүртгэж, гэрээг олон нийтэд ил тод болгох ажлыг эхлүүлжээ.

2.5 Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолоор “ТӨБЗГ-аас 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалт”-д 15 ТЕЗ-ийн 835.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 398.6 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 536 ТАХ-ний худалдан авах ажиллагааг тус газар зохион байгуулахаар баталсан байна.

2.6 ТӨБЗГ тайлант онд 144 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, 392 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг орон нутагт ТЕЗ нартай хамтарсан тушаалаар шилжүүлжээ.

2.7 ТЕЗ нар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁹ дэх заалт, Засгийн газрын 2017 оны 315 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт “Энэ тогтоолын хавсралтад заасан ТАХ-ний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг хуульд заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ТЕЗ нарт даалгасугай” заасныг зөрчин дараах 7 ТАХ-ний зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг тус газарт ирүүлээгүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжгүй болж, захиалагчид буцаасан байна. Тухайлбал,

ЭМС-ын багц:

- Дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо, Хайлааст салбар/,

БСШУСС-ын багц:

- Сургуулийн спорт заалны барилгын дуусгал /Дундговь, Хулд сум/,

ЗТХС-ын багц:

- Сумын төвөөс 8 дугаар баг хүртэл хатуу хучилттай автозам 1 км /Сэлэнгэ, Сүхбаатар сум/,
- Орхон голын гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/,

УУХҮС-ын багц:

⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



- Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн үйлдвэрийн гаднах дэд бүтэц /салбар төмөр зам, автозамын инженерийн хайгуулын ажил, ТЭЗҮ, зураг төсөө боловсруулах болон барилгын ажлын техник технологийн байнгын хяналт/,

БХБС-ын багц:

- Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/.

2.8 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар БСШУСС-ын багцад батлагдсан ТАХ-г хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар зах зээлийн үнийг тогтоолгохгүйгээр худалдан авалт хийсэн байна. Үүнд:

- Улаанбаатар, БЗД-ийн 25 дугаар хороонд 200 ортой 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга худалдан авах төслийг хэрэгжүүлэхдээ үйлчилгээний зориулалттай баригдсан барилгыг 2,489.8 сая төгрөгөөр худалдан авах гэрээг “Үлэмж бит” ХХК-тай байгуулсан байна. Гэрээний үнэд газрын зардал 778.0 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн үнэ 1,152.0 сая төгрөг, давхар нэмж барихад 559.7 сая төгрөгийн зардлууд багтсан.
- Улаанбаатар, БЗД-ийн 10 дугаар хороонд 960 хүүхдийн суудалтай 4,350.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төслийг хэрэгжүүлэхдээ “Түмэн-Өргөө хаус” ХХК-тай 4,348.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээг байгуулсан байна. Гэрээний үнэд үл хөдлөх хөрөнгийн үнэ 4,340.0 сая төгрөг, засвар үйлчилгээний зардал 8.0 сая төгрөг тус тус багтсан байна. Тус сургууль нь 500 хүүхдийн хүчин чадалтай бөгөөд хуульд батлагдсан хүчин чадлаас 460 суудлаар бага байна. 2018 онд 3,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон, 2019 онд 1,348.0 сая төгрөг олгохоор байна.

2.9 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.21-т “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчин ЭМС-ын багц батлагдсан төсвөөс хэтрүүлэн гэрээ байгуулж, нэрийг өөрчилсөн байна. Тухайлбал,

- Сайдын 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн А/300 дугаар тушаалын хавсралтаар баталсан 10.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй албан тасалгааны тоног төхөөрөмжийг 12.8 сая төгрөгөөр, 26.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй эмнэлгийн автомашиныг 31.0 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээг төсөвт өртгийг хэтрүүлэн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, санхүүжилтийг олгосон.
- Хэнтий аймгийн Мөрөн суманд худалдан авах эмнэлгийн автомашиныг сайдын тушаал зөрчин өөрчилж тоног төхөөрөмж худалдан авсан байна

Эрх шилжүүлсэн зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд шилжүүлээгүй байна

2.10 ТЕЗ нар тайлант онд хэрэгжүүлэх 749 ТАХ-ний 40.2 хувь буюу 301 ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг аймаг, нийслэлийн Засаг дарга болон харьяа байгууллагуудад шилжүүлсэн байна.

2.11 БХБС-ын багц Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдсанаас 4-11 сарын дараа дараах 55 ТАХ-ний эрхийг шилжүүлснээс шалтгаалан хэрэгжилт 76.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 13 дугаар тушаалаар 45,
- 2018 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 40 дүгээр тушаалаар 2,
- 2018 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 115 дугаар тушаалаар 2,
- 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 142 дугаар тушаалаар 5,
- 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 165 дугаар тушаалаар 1.

2.12 ТӨБЗГ-аас УИХ-ын гишүүдийн хүсэлтийг үндэслэн дараах 7 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг ТЕЗ болон орон нутагт шилжүүлжээ. Тухайлбал,

ЭМС-ын багц:

- Дархан-Уул аймгийн төрөх эмнэлгийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Дархан сум/ Монгол Улсын Их хурлын гишүүн Б.Баттөмөрийн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 5377 дугаар албан бичиг, Эрүүл мэндийн яамны 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 2/1899 дугаар албан бичгээр,

МУШС-ын багц:

- Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/,

БСШУСС-ын багц:



- Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/,
- ЗТХС-ын багц:**
 - Нарийн голын модон гүүр /Баян-Өлгий, Толбо сум/
 - Хойд голын модон гүүр /Баян-Өлгий, Толбо сум/,
- БОАЖС-ын багц:**
 - Ус цаг уур, орчны шинжилгээний газрын барилга /Увс, Улаангом сум/,
- МУЕП-ын багц:**
 - Прокурорын газрын барилга /Ховд, Жаргалант сум/.

2.13 Орон нутагт эрх шилжсэн ТАХ-ний хэрэгжилтэд аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд аудит хийж, нийт 43.5 тэрбум төгрөгийн 332 зөрчлийг илрүүлж, 12 зөрчлийг нөхөн төлүүлэхээр 0.6 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 156 зөрчлийг арилгуулахаар 20.8 тэрбум төгрөгийн албан шаардлага, 160 зөрчлийг арилгуулахаар 22.6 тэрбум төгрөгийн зөвлөмж өгч, зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах 4 саналыг дээд шатны удирдлагад хүргүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын илрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /сая төгрөг/

№	Аймаг, нийслэлийн нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Зөвлөмж өгсөн		Төлбөрийн акт тогтоосон		Албан шаардлага өгсөн		Хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Архангай	24	1,181.7			1	0.3	23	1,181.4		
2	Баян-Өлгий	9	2,755.3	1				8	2,755.3		
3	Баянхонгор	11	2,676.6	4				7	2,676.6		
4	Булган	3	88.1			1	0.3	2	87.8		
5	Говь-Алтай	16	4,721.0	4	327.0	4	29.3	8	4,364.7		
6	Говьсүмбэр	7	1,009.9	7	1,009.9						
7	Дархан-Уул	5	107.0	3				2	107.0		
8	Дорноговь	8	1,648.4	5				3	1,648.4		
9	Дорнод	6	8,107.5	4	7,717.5			2	390.0		
10	Дундговь	11	50.5	2		1	1.0	8	49.5		
11	Завхан	6	390.5	2	199.5			4	191.0		
12	Орхон	6	369.9	5	369.9			1			
13	Өвөрхангай	20	168.6	8				12	168.6		
14	Сүхбаатар	4	1,835.4	2				2	1,835.4		
15	Сэлэнгэ	10	878.1			1	10.0	5	868.1	4	
16	Төв	18	1,751.4			3	9.5	15	1,741.9		
17	Увс	2	1,805.2	2	1,805.2						
18	Ховд	15	672.8	8				7	672.8		
19	Хөвсгөл	6	10,557.1	5	10,552.0	1	5.1				
20	Хэнтий	138	2,693.3	93	654.3			45	2,039.0		
21	Нийслэл	7	-	5				2			
ДҮН		332	43,468.3	160	22,635.3	12	55.5	156	20,777.5	4	-

2.14 Аудитын явцад аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд дараах зөрчлүүдийг илрүүлсэн байна. Тухайлбал,

Төлбөрийг барагдуулах акт тогтоосон зөрчлүүдээс дурдвал:

- Архангай аймгийн МСҮТ-ийн халаалтын тогооны засварын ажлын гүйцэтгэгч "БГБС" ХХК-д зохиогчийн хяналт хэрэгжүүлснийг нотлох анхан шатны баримтгүйгээр 0.3 сая төгрөгийг олгосон,
- Булган аймгийн Гурванбулаг сумын ЭМТ-ийн их засварын ажлын гүйцэтгэгч "Бүлээн оргил" ХХК-д гэрээний дүнгээс 33.0 мянган төгрөгийн илүү санхүүжилт олгосон,
- Говь-Алтай аймаг гэрээт хугацаанд ажлыг хүлээлгэн өгөөгүй 6 ажилд гэрээнд заасны дагуу нийт 19.3 сая төгрөгийн алдангийг тооцож төлүүлээгүй, захиалагчийн хяналтын зардлын 10.0 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр шилжүүлснийг 60 жилийн ойн үйл ажиллагаанд зориулан "Барилгачдын холбоо" ТББ-д шилжүүлэн зориулалт бусаар зарцуулсан,
- Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын "Халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилга"-ын ажлын инженер-хайгуулын зардлын 1.0 сая төгрөгийн урьдчилгааг сумын ОНХС-аас "Жонш-Уул" ХХК-д шилжүүлсэн боловч дахин улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвөөс санхүүжилтийг олгосон,
- Сэлэнгэ аймгийн ЗДТГ авто машин худалдан авах ажлын 10.0 сая төгрөгийг гүйцэтгэгч "Шинэбадрах" ХХК-д шилжүүлсэн боловч "төсвөт өртөг хүрэхгүй, 2019 оны ОНХО-аас үлдээгдэл санхүүжилтийг олгоно" гэсэн шалтгаанаар авто машин нийлүүлэгдээгүй байхад ашиглалтад хүлээн авсан акт болон санхүүгийн тайланд бүртгэсэн тодорхойлолтыг хуурамчаар үйлдсэн.
- Төв аймгийн Архуст сумын цэцэрлэгийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч "Тусгал төв" ХХК-иас гэрээт хугацааг 19 хоног хэтрүүлсний 0.4 сая төгрөгийн алдангийг тооцож аваагүй, 5.1 сая



төгрөгийн алдангийг дутуу тооцсон, БЗОСК-д 9.1 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг илүү олгосон.

Албан шаардлага өгсөн зөрчлүүдээс дурдвал:

- Архангай аймаг 3 барилга байгууламж, их засварын ажлын бодит гүйцэтгэлээс 793.9 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон, захиалагчийн хяналт хангалтгүй хийснээс зураг төсөвт тусгасан 112.1 сая төгрөгийн ажлыг дутуу хэрэгжүүлж, гэрээний үүргээ биелүүлээгүй 2 гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан 275.4 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг ашиглагчийн санхүүгийн тайланд тусгаагүй,
- Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэгч “Ганбарс” ХХК, Буянт сумын Халуун усны барилгын ажлын гүйцэтгэгч “Монстрой Эра” ХХК, Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологиын тасгийн засварын ажлын гүйцэтгэгч “Көркем” ХХК, Орон нутгийн судлах музейн засварын ажлын гүйцэтгэгч “Мурап” ХХК-ийн гүйцэтгэж байгаа нийт 1,447.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд дуусгаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, захиалагчийн хяналт хангалтгүй хэрэгжсэн, Баяннуур сумын ногооны зоорь, Алтай сумын услалтын систем, Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилга, Буянт сумын Халуун усны барилга зэрэг 1,307.8 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэлд тусгаагүй,
- Баянхонгор аймгийн Баян-Ойт сургуулийн 1,973.5 сая төгрөгийн өртөгтэй барилгыг улсын комисс хүлээж аваагүй байхад сургалтын үйл ажиллагааг явуулсан,
- Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын 2018 оны А/109 тоот захирамжаар Үнэлгээний хороог хуурамчаар байгуулж, 2016 онд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн “Нэгдсэн халаалтын зуух, гадна дулааны шугамын засвар, шинэчлэлт”-ийн 1,746.1 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, “Сан” ХХК-ийг шалгаруулан 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр гэрээ байгуулсан.

2.15 ЭМС эрх шилжүүлээгүй байхад Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” заасныг зөрчин Дархан-Уул аймгийн Засаг дарга, Завхан аймгийн Засаг дарга нар худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, санхүүжилт олгох ажлыг гүйцэтгэсэн байна.

Захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаа, дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулаагүй байна

2.16 ТӨБЗГ-ын 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тайлант оны 1, 2 дугаар сард багтаан Үнэлгээний хороог байгуулахаар тусгасан боловч 114 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дунджаар 102 хоног хоцроож байгуулжээ.

Хүснэгт 8. Үнэлгээний хороо байгуулсан хугацаа /хоног, төслийн тоо/

№	Захиалагч	ТАХ-ний тоо	Хугацаа хоцорсон төсөл арга хэмжээ	
			тоо	хоног /дунджаар/
1	ЭХЯ	7	3	60
2	БӨАЖЯ	8	2	91
3	БХБЯ	4	4	151
4	ЗТХЯ	12	11	75
5	ЭМЯ	35	35	116
6	БСШУСЯ	59	59	123
Нийт		120	114	102.7

Эх сурвалж: ТӨБЗГ

2.17 Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8-д “Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд

эхлүүлэх” заасныг хэрэгжүүлээгүйгээс шалтгаалсан байна.

2.18 Тендерт оролцогчид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54 дүгээр зүйлд “Захиалагчид гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх”, 55 дугаар зүйлийн 55.1-д “Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт



бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана”, 56 дугаар зүйлийн 56.1-т “Гомдлыг энэ хуулийн 55.2-т заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрвөл тендерт оролцогч нь шүүхэд гомдол гаргаж болно” заасныг тус тус үндэслэн тендерт оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүд 2018 онд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 198, Сангийн яаманд 1187, Шүүх байгууллагад 61 гомдол гаргасан байна.

2.19 Сангийн яам 2018 онд нийт 962 тендертэй холбоотой 683 иргэн, аж ахуйн нэгжээс 1187 гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, хариу өгчээ.

2.20 Нийт гомдлын 639 буюу 53.8 хувийг тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх, 378 буюу 31.9 хувийг захиалагчийн шийдвэр хуульд нийцсэн, гомдол үндэслэлгүй, 170 буюу 14.3 хувийг тендерийг хүчингүй болгох шийдвэрийг тус тус гаргасан байна.

2.21 Энэ нь үнэлгээний хорооны гишүүд тендерийн үнэлгээг хийхдээ зохих хууль, журмыг хэрэгжүүлээгүй, захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой.

2.22 Сангийн яам 2018 онд ирсэн нийт гомдлын 809 буюу 68 хувь нь тендерийг хүчингүй болгох, үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх шийдвэрийг гаргасан байхад хуулийн шаардлага хангаагүй гүйцэтгэгч шалгаруулж, хууль, журмын дагуу ажиллаагүй үнэлгээний хорооны гишүүдэд ТЕЗ нар хариуцлага тооцож, арга хэмжээ аваагүй байна. Тухайлбал,

- БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн А/26 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо Баян-Өлгий аймгийн Өлгий суманд хэрэгжүүлж буй 1,154.2 сая төгрөгийн өртөгтэй “Барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн барилга”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, журмыг зөрчин шаардлага хангаагүй байхад 2018.05.15 болон 2018.06.22-ны өдрийн шийдвэрээр “Минда” ХХК болон “Мадине” ХХК-ийн түншлэлийг 2 удаа шалгаруулсныг Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болгожээ.

2.23 Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 47 дугаар зүйлийн 47.2.2-т “тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах...”, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 3.5.2-т “Үнэлгээний хорооны дарга нь хуралдааныг товлох, үнэлгээний хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үнэлгээний хорооны үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах” заасныг тус тус зөрчсөн тул Үнэлгээний хорооны дарга болон гишүүдэд хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

2.24 Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ..., төсөвт тусгаадаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” заасныг зөрчин зарим ТЕЗ нар улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ангилал, зориулалтыг өөрчилсөн



асуудлыг энэхүү аудитын цаглабарт хугацаанд бүрэн хамруулах боломжгүй байдал үүссэн. Иймд дээрх асуудлыг эрсдэлийн аудит хийхээр шийдвэрлэлээ.

2.25 Зарим ТЕЗ нар Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.22-т *“Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй”* заасныг зөрчин төсвийн хэмнэлтээс нэмэлт гэрээ байгуулж, тоног төхөөрөмж худалдан авсан байна. Тухайлбал,

ХЗДХС-ын багц:

- Яам болон харьяа газрууд тендерийн хэмнэлтээс 674.1 сая,

БСШУСС-ын багц:

- Тендерийн хэмнэлтээс 766.2 сая,

АТГ-ын дарга:

- Тендерийн хэмнэлтээс 13.8 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

2.26 ЭМС-ын багц Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д *“... төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”* Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.22¹⁰ -т заасныг тус тус зөрчин төсвийн хэмнэлтээс шинэ арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж санхүүжүүлсэн, нэмэлт гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байна. Тухайлбал,

- Сайдын “Жагсаалт батлах тухай” 2018 оны А/03 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан гадна шугам сүлжээ, сантехникийн засвар /Улсын гуравдугаар төв эмнэлэг/ ТАХ-ний тендерийн хэмнэлтээс Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуульд батлагдаагүй ТАХ болох сантехникийн хэсэгчилсэн засвар хийх /Уламжлалт анагаах ухааны хүрээлэн/ ажилд 20.0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна

2.27 ТӨБЗГ болон ТЕЗ нар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д *“Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 01-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана”* гэж заасныг үндэслэн 2018 онд хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тайланг Сангийн яаманд хүргүүлжээ.

2.28 Сангийн яамнаас ТЕЗ нарын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, цахим тендер шалгаруулалтын урилга, тендерийн үр дүн, тендертэй холбоотой ирсэн гомдлын судалгаа зэрэгт үндэслэн Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлтээр 2018 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дундаж үнэлгээ өгсөн байна.

2.29 Сангийн яам улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ТАХ, барилга байгууламжийн жагсаалтаар баталсан дараах 22 ТЕЗ нарын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг дунджаар 70.5 хувь буюу “Хангалттай” гэж үнэлжээ.

¹⁰ Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй.



Хүснэгт 9. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны үнэлгээ /хувь/

№	ТЕЗ	Худалдан авах ажиллагааны үнэлгээ			2018 оны		№	ТЕЗ	Худалдан авах ажиллагааны үнэлгээ			2018 оны	
		2015	2016	2017	хувь	үнэлгээ			2015	2016	2017	хувь	үнэлгээ
1	ХЗДХС	62	51.5	84.3	86.0	Сайн	12	ҮХЦ				71.6	Хангалттай
2	МУЕС		27	75	83.8	Сайн	13	ХХААХҮС	40	40	72.5	67.0	Хангалттай
3	ЗГХЭГ		27	77.1	82.7	Сайн	14	ГХС	35	61.3	58.1	63.7	Хангалттай
4	БХС	35	25	60	82.3	Сайн	15	УЕП	74	80	41.7	63.5	Хангалттай
5	ЗТХС	36.5	33	92	81.6	Сайн	16	МУЕА	53.5	46		60.0	Хангалттай
6	АТГ	53			81.0	Сайн	17	ХНХС	62	42	69.1	58.9	Хангалтгүй
7	СС	62	50	73.8	75.5	Хангалттай	18	ЭХС	60	46	68.9	58.8	Хангалтгүй
8	МУШС	50.5	38	75	74.4	Хангалттай	19	БСШУСС	46	25	60	52.2	Хангалтгүй
9	БОАЖС	49	35	72.5	73.3	Хангалттай	20	БХБС	37	23	59.6	48.5	Хангалтгүй
10	УУХҮС	60	66.9	84.8	73.3	Хангалттай	21	МУИХ		38	60		
11	ЭМС	60	37	68.8	71.6	Хангалттай	22	МУЕТГ					
ДУНДАЖ ХУВЬ							51.5 41.7 69.6 70.5						

Эх сурвалж: Сангийн яам

2.30 МУЕТГ болон МУИХТГ бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4¹¹ -т заасныг үндэслэн хэрэгжүүлсэн тул үнэлгээ хийгдээгүй байна.

2.31 Үнэлгээ хийгдсэн ТЕЗ-дын 73 хувь нь сайн буюу хангалттай үнэлгээ авч, дундаж үнэлгээ сүүлийн 3 жилийн дунджаас 16.2 пунктээр өсөж худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт сайжирчээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэл 72.6 хувьтай байна

2.32 Сангийн яам улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх 678 ТАХ-нд 580.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 84.9 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

2.33 Аудитын явцад 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний бодит гүйцэтгэлийг тооцож үзэхэд 496.6 тэрбум төгрөг буюу 72.6 хувийн гүйцэтгэлтэй байна. (Дэлгэрэнгүйг Хүснэгт 3-аас үзнэ үү)

2.34 Энэ нь ТАХ-ний худалдан авах ажиллагаа оройтож зарлагдсан, ажил гүйцэтгэх гэрээг барилгын улирал дуусах үед байгуулсан зэргээс шалтгаалан Засгийн газрын 2018 оны 386 дугаар тогтоолыг үндэслэн гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгаа болон ТЕЗ нарын санхүүжилт хүссэн албан бичгийг үндэслэн 83.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосонтой холбоотой байна.

2.35 Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар 212.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 57.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 71 ТАХ хэрэгжээгүй байгаа нь тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний 9.5 хувь, санхүүжилтийн 8.4 хувийг эзэлж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү)

2.36 Тайлант онд хэрэгжээгүй ТАХ-ний 19.8 хувь нь худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүйгээс, 39.4 хувь нь худалдан авах ажиллагаа хүчингүй болсноос, 8.5 хувь нь худалдан авах ажиллагаа хийгдсэн боловч гэрээ байгуулагдаагүйгээс, 7.0 хувь нь гүйцэтгэгч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүйгээс, 1.4 хувь нь шаардлагагүй арга хэмжээг төлөвлөснөөс, 23.9 хувь нь бусад шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Хүснэгт 10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 онд хэрэгжээгүй ТАХ-ний судалгаа /сая төгрөг/

ТЕЗ	Төслийн тоо	Эзлэх хувь	Санхүүжих дүн
БСШУСС	31	43.7	25,865.8
БХБС	11	15.5	6,729.3
ЗТХС	9	12.7	7,761.4
ХХААХҮС	8	11.3	2,890.0
ЭМС	4	5.6	6,671.8
СС	3	4.2	5,990.0
МУЕС	1	1.4	829.5
МУШС	1	1.4	100.0
ЗГХЭГ	1	1.4	750.0
ХНХС	1	1.4	30.0
УУХҮС	1	1.4	143.1
НИЙТ ДҮН	71	100.0	57,761.0

¹¹ Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.



2.37 Тайлант онд 204.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 50.3 тэрбум төгрөгөөр санхүүжих дүнтэй 58 ТАХ дутуу хэрэгжсэн нь төлөвлөсөн ТАХ-ний 7.9 хувь, санхүүжилтийн 7.4 хувийг эзэлж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү)

2.38 Дутуу хэрэгжсэн ТАХ-ний 24.2 хувь нь гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, 4.5 хувь нь санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс, 6 хувь нь зураг төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийгдсэнээс, 3 хувь нь гадна инженерийн дэд бүтэц шийдэгдсэнээс, 62.3 хувь нь гэрээ байгуулсан хугацаанд хэрэгжих боломжгүйгээс шалтгаалжээ.

2.38 Тайлант онд нийт 129 ТАХ-ний хэрэгжилт бүрэн хангагдаагүйгээс батлагдсан санхүүжилтийн 15.1 хувь буюу 102.9 тэрбум төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Барилга угсралтын ажил гүйцэтгэгч зарим компани гэрээний үүргээ биелүүлээгүй, зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэхгүй байна

2.39 Захиалагч болон ажил гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын ажлын зохион байгуулалт хангалтгүйгээс ажил гүйцэтгэх боломж олгоогүй, зарим ажлыг гүйцэтгээгүй байхад хариуцлага тооцоогүй, гэрээний хугацааг сунгаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ. Тухайлбал,

БХБС-ын багц:

- “Ээлт өлгий” ХХК 429.5 сая төгрөгийн Орхон аймгийн Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн 900 м үерийн хамгаалалтын барилга байгууламж далангийн барилга угсралтын ажлыг 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор гүйцэтгэн ашиглалтад оруулахаар 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдөр 2018/100 дугаар гэрээ байгуулсан боловч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан цэвэрлэх байгууламжийн түшиц ханын цутгалтын ажил дуусаагүйгээс ажлын гүйцэтгэл 90 хувьтай,
- “Сайн констракшн” ХХК 8,519.1 сая төгрөгийн 2013 онд эхэлж, он дамжин хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур, 2 ширхэг биоцөөрөм барих ажил”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны дотор гүйцэтгэн ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан боловч био цөөрмийн карт тавих газрын асуудал шийдэгдээгүйгээс 80 хувьтай,
- “Мон энерги” ХХК 788.0 сая төгрөгийн “Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, ИШС-ний зураг төслийн ажил”-ыг 2018 оны 9 дүгээр сарын 27-ны дотор гүйцэтгэн ашиглалтад оруулахаар 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулж, нийт 777.0 сая төгрөгийн буюу 99 хувийн санхүүжилтийг авсан боловч бодит ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна. Олгосон санхүүжилтийн 236.4 сая төгрөгийг Засгийн газрын 2018 оны 386 дугаар тогтоолыг үндэслэн гүйцэтгэгчийн банкны баталгааг үндэслэн олгосон,
- “Эн Ар Жи Эм” ХХК 796.5 сая төгрөгийн “Сумын төвлөрсөн зуухны БУА /Говь-Алтай, Жаргалант/-ыг 2018 оны 12 дугаар 15-ны дотор гүйцэтгэн ашиглалтад оруулахаар 2017 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр гэрээ байгуулсан боловч захиалагчийн хяналтаар гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ шалны түвшин зөрүүтэй, суурийн бетон цутгалтын ажлыг 2017 оны 10-р сард бетон хольцын хүйтний нэмэгдэлтэй гүйцэтгэхдээ бетоноос дээж авч лабораторийн шинжилгээнд ирүүлээгүй зөрчил илэрсэн тул газар дээр нь эвдэх аргаар иж бүрэн шинжилгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, зөрчил илэрвэл арилгах үүрэг өгснийг хэрэгжүүлээгүй, ажлын гүйцэтгэл 70 хувьтай,

БСШУСС-ын багц:

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 95 хувьтай байхад 2018.12.01-ний өдөр гэрээний хугацаа дууссан,
- Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаан хаан тосгон/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 86 хувьтай байхад 2018.08.20-ны өдөр гэрээний хугацаа дууссан,
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 81.5 хувьтай байхад 2018.12.30-ны өдөр гэрээний хугацаа дууссан,
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Сэлэнгэ, Алтанбулаг сум/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 88 хувьтай байхад 2018.12.30-ны өдөр гэрээний хугацаа дууссан,
- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 50.2 хувьтай байхад 2018.08.20-ний өдөр гэрээний хугацаа дууссан,
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Төв, Жаргалант сум/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 82.6 хувьтай байхад 2018.11.25-ны өдөр гэрээний хугацаа дууссан,
- Цэцэрлэгийн барилга, 75 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 85 хувьтай байхад 2018.12.25-ны өдөр гэрээний хугацаа дууссан.
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Эрдэнэ сум/ төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэл 72.5 хувьтай байхад 2018.12.20-ны өдөр гэрээний хугацаа дууссан.



2.40 БСШУСС-ын багцад батлагдсан зарим ТАХ-ний ажлын гүйцэтгэгч Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2¹², 40.1.5¹³, 40.1.16¹⁴, 40.1.17¹⁵, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3¹⁶, 28.1.4¹⁷ дэх заалт, цутгамал бетон, төмөр бетон бүтээцийн “Барилгын норм ба дүрэм”-ийн 51-02-05, 52-02-05 дахь заалтыг тус тус зөрчин зураг, төсвийн дагуу барилга угсралтын ажлыг гүйцэтгээгүй байна. Тухайлбал,

- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/ ТАХ-ний барилгын үндсэн хийц болох өрлөгийн ажлыг норм, стандартын дагуу гүйцэтгээгүйгээс ашиглалтад хүлээн авах боломжгүй болсон.
- Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 14 дүгээр хороо/ төсөл арга хэмжээний барилгын дотор ханын өрлөгийг зураг төслөөс зөрчиж 10 см-ийн зузаантай хөнгөн блокыг өрлөгийн тор, бэхлэгээгүй өрсөн. Багана хоорондын алхам В, С тэнхлэгийн дагуу 5-7см алдсан, Багана дам нурууны уулзвар хэсэгт тасалж цутгасан, Хэв хашмалыг тэгш бус угсарч багана, дам нуруу, хучилтад цүлхийлт үүссэн, бетоны нягтруулалт хийгдээгүй, Гадна ханын өрлөгт өрлөгийн тор тавиагүй өрсөн, баганатай холбосон бэхлэгээ угсраагүй, шатны алхам алдаж цутгасан, 1 давхарт шалны түвшин алдаж цутгасан.

2.41 Цаашид ТЕЗ нар гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын ажлын хариуцлагыг сайжруулах, барилга байгууламжийг дутуу орхих, төсвийн хөрөнгийг үргүйдүүлэх асуудлыг зогсоохын тулд ажлын үр дүнгээр хариуцлага тооцож байх тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна

2.42 БСШУСС, ЭМС, БХБС-ын багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналт хийх гэрээг захиалагчийн техник хяналтыг гүйцэтгэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ байгуулж, ажлын үр дүнг дүгнэж, санхүүжилтийг олгож байна.

2.43 Энэ тогтолцоо нь Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.1-т “Захиалагч нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргээс гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ”, 3.1.4-т “Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээг байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах”, БХБС-ын 2015 оны 185 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 2.1-т “Зураг төсөл зохиогч барилгын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина” гэж заасныг тус тус зөрчиж байна.

2.44 Цаашид захиалагч барилга угсралтын ажилд зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг зураг төсөл зохиогч компанитай байгуулж, зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэн гэрээний хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрд дүгнэлт гаргуулж, үр дүнг тооцон зохих санхүүжилтийг олгож, байх шаардлагатай байна.

2.45 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2.1¹⁸ дугаар зүйлд тодорхойлсон бөгөөд мөн

¹² барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх,

¹³ барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх,

¹⁴ барилгын ажлын талбайн орчны хөдөлмөр хамгааллын дэглэмийг сахиулж, гуравдагч этгээдийг барилгын ажлаас шалтгаалсан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах,

¹⁵ барилгын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй байх”, “барилгын ажлын явцад зураг төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах,

¹⁶ хөдөлмөр эрхлэлтийн явцад гарч болзошгүй осол, бэртэл, өвчлөлөөс ажилтныг хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх,

¹⁷ ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх

¹⁸ 45.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн захиргааны төв болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага, Үндсэн хуулийн цэц, Улсын



хуулийн 46 дугаар зүйлийн 46.2¹⁹-д захиалагчийг хэн төлөөлөхийг зааж өгсөн байна. Уг заалтад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхээр заасан боловч орон нутагт захиалагчийн хяналтыг өөр өөр байгууллага хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- Дундговь аймагт ГХБХБГ,
- Хөвсгөл аймагт ОНӨГ,
- Хэнтий аймагт ЗДТГ, Эрүүл мэндийн газар, ГХБХБГ, ИЗБНХ, НҮТББ,
- Увс аймагт ГХБХБГ,
- Говьсүмбэр аймагт ЗДТГ, ГХБХБГ,
- Дархан-Уул аймагт ГХБХБГ, Хот байгуулалт, барилга захиалагчийн газар

2.46 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т “Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” заасныг үндэслэн аймгийн ЗДТГ-ын ерөнхий менежерүүд хуулиар өөрт олгогдсон эрхийг шилжүүлсэн шийдвэрийг гаргаагүй байна.

2.47 Захиалагчийн хяналтын зардлыг зарцуулах нарийвчилсан зохицуулалт байхгүйгээс захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдолгүй үйл ажиллагаанд зарцуулах эрсдэл өндөр байна.

2.48 Холбогдох эрх бүхий албан тушаалтан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналтын зардлыг зарцуулах нарийвчилсан журамтай болох шаардлагатай байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүйгээс хийгээгүй ажилд санхүүжилт олгосон байна

2.49 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүйгээс Засгийн газрын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 386 дугаар тогтоолын 1.2-т “... салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын зарим ТАХ-ний санхүүжилтийг банкны баталгааг үндэслэн олгох” эрх олгосны дагуу нийт 136 ТАХ-ний 71.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн олгосон байна. Тухайлбал,

- БСШУСС-ын багц 71 ТАХ-ний 29,639.5 сая,
- ЭМС-ын багц 20 ТАХ-ний 14,324.6 сая,
- БХБС-ын багц 20 ТАХ-ний нийт 9,668.2 сая,
- ЗТХС-ын багц 10 ТАХ-ний 7,057.0 сая,
- БОАЖС-ын багц 3 ТАХ-ний 4,286.4 сая,
- ЭХС-ын багц 3 ТАХ-ний 1,809.0 сая,
- ХХААХҮС-ын багц 2 ТАХ-ний 1,760.0 сая,
- ХНХС-ын багц 3 ТАХ-ний 1,650.9 сая,
- ЗГХЭГ-ын даргын багц 1 ТАХ-ний 580.0 сая,
- МУШС-ын багц 1 ТАХ-ний 125.0 сая,
- УУХҮС-ын багц 2 ТАХ-ний 526.9 сая төгрөг.

дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн хэрэгцээнд худалдан авах бүх бараа, ажил, үйлчилгээний хувьд;

45.2.2.аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд.

¹⁹ Энэ хуулийн 4.1.1-д заасан захиалагчийг төлөөлж төсвийн ерөнхий менежер, 4.1.2-т заасан захиалагчийг төлөөлж гүйцэтгэх захирал энэ хуулийн 46.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.



2.50 БСШУСС-ын багцаас урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон зарим ТАХ-ний гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн баталгаанд хүчинтэй байх хугацааг зааж өгснөөс шалтгаалан гүйцэтгэгчийн хүлээх үүрэг биелэгдээгүй байхад хугацаа нь дуусаж, арилжааны банкны баталгаа чөлөөлөгдсөн байна. Үүнд:

- Сургуулийн барилга 240 суудал /Хөвсгөл, Эрдэнэбулган/-ын гүйцэтгэгч “Юувоку” ХХК-ийн ХХБ-ны 299.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгааны хүчинтэй хугацаа 2019 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр,
- Дотуур байрны барилга, 75 ор /Хөвсгөл, Улаан-Уул/-ын гүйцэтгэгч “Агар эрдэнэс трейд” ХХК-ийн ХААН банкны урьдчилгаа төлбөрийн баталгааны хүчинтэй хугацаа 2019 оны 3 дугаар сарын 31-ний өдөр,
- Цэцэрлэгийн барилга, 75 ор /Баян-Өлгий, Ногооннуур/-ын гүйцэтгэгч “Химон констракшн” ХХК-ийн Богд банкны 87.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгааны хүчинтэй хугацаа 2019 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр,
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Төв, Жаргалант/-ын гүйцэтгэгч “Ган цаг” ХХК-ийн ХХБ-ны 136.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгааны хүчинтэй хугацаа 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдөр тус тус дуусгавар болсон байна.

2.51 ТЕЗ нар “Санхүүжилт хүсэх тухай” албан бичгийг Сангийн яаманд хүргүүлж, ажлын гүйцэтгэл нь гараагүй, урьдчилгаа төлбөрийн баталгаа байршуулаагүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй 12.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгө оруулалтын дансаар дамжуулан барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна. Тухайлбал,

- БСШУСС-ын багц: 9 ТАХ-ний 7,669.1 сая,
- ХХААХҮС-ын багц: 1 ТАХ-ний 258.8 сая,
- БХБС-ын багц: 3 ТАХ-ний 940.1 сая,
- ЭМС-ын багц: 1 ТАХ-ний 230.3 сая,
- НХОГ-ын газар: 4 ТАХ-ний 3,350.0 сая төгрөг

2.52 Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7²⁰, 11 дүгээр зүйлийн 11.1.2²¹, 45 дугаар зүйлийн 45.2²², 45.2.2²³, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7²⁴ дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 386 дугаар тогтоолын 1.2²⁵ дахь хэсэг, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3²⁶, 5.4²⁷ дэх заалтыг тус тус зөрчсөн тул 12.4 тэрбум төгрөгийн албан шаардлага өглөө.

2.53 Зарим ТЕЗ нар ажлын гүйцэтгэл гараагүй, байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллаагүй, урьдчилгаа төлбөрийн баталгаа байршуулаагүй, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй байхад үлдэгдэл санхүүжилтийг техник хяналтын зардлын дансанд байршуулсан байна. Тухайлбал,

- БОАЖС-ын багц: Цаг уурын шинжилгээний өртөөний барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/-ын угсралтын ажлын гэрээний дүнгийн 10 хувь буюу 9.0 сая төгрөг,
- ХХААХҮС-ын багц: Өмнөговь аймгийн Засаг даргаас тухайн оны барилга угсралтын ажлын зураг, төсвийн үнийг ажлын гүйцэтгэлд оруулан тооцсоныг гүйцэтгэл ирүүлээгүй шалтгаанаар суутгасан 33.4 сая төгрөг

²⁰ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

²¹ Санхүү, төсвийн удирдлагын асуудлаар өөрийн эрх хэмжээний хүрээнд заавар, журам батлан гаргах.

²² Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.

²³ Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл.

²⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

²⁵ Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд сургууль, цэцэрлэгийн барилгыг 2019 онд бүрэн ашиглалтад оруулах, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг банкны баталгааг үндэслэн олгох.

²⁶ Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан норм, норматив, дүрэм болон тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын үе шатны ажлын хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, баталгаажуулна.

²⁷ Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.



2.54 Аудитын явцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж 2018 онд ашиглалтад оруулсан болон ашиглалтад ороход бэлэн болсон 25 барилга байгууламжийн зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэлд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулсан.

2.55 Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээр барилгын норм дүрмийн дагуу төсвийн үнэлгээ хийгдээгүйгээс үүссэн зөрүү, бодит бус ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, БСШУСС-ын багц 8 ТАХ-нд 309.6 сая төгрөг, ЭМС-ын багц 1 ТАХ-нд 25.9 сая төгрөг, нийт 335.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид илүү олгосон зөрчил илэрсэн нь гүйцэтгэгч компаниар нөхөн хийлгэх боломжгүй тул хохирлыг төлүүлэхээр акт тогтоолоо.

2.56 Мөн ТАХ-ний ажлын гүйцэтгэлийг барилга угсралтын ажлын зураг, төсөвтэй нь тулган баталгаажуулахад барилгын норм дүрмийн дагуу төсвийн үнэлгээ хийгдээгүйгээс үүссэн зөрүү, бодит бус ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, БСШУСС-ын багц 14 ТАХ-ний 3,531.3 сая төгрөг, ЭМС-ын багц 2 ТАХ-ний 13.4 сая төгрөг, нийт 3,544.7 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид илүү олгосон зөрчлийг илрүүлж, гүйцэтгэгч компаниар нөхөн хийлгэхээр хугацаатай албан шаардлага өглөө.

2.57 Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Барилгын тухай хуулийн 40 зүйлийн 40.1.1-т “*барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих*” заасныг тус тус зөрчсөн байна.

2.58 Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг БСШУСС буюу захиалагч хэрэгжүүлж ажиллахгүй байгаагаас барилгын ажлын чанар, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, хийгээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжилт олгох хүсэлтийг Сангийн яаманд хүргүүлдэг нийтлэг дутагдал байсаар байна. Тухайлбал,

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн барилга угсралтын ажлын 9 дүгээр гүйцэтгэлээр 113.2 сая төгрөгийг суурийн ажлын актгүй,
- Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Өмнөдэлгэр сум/ ТАХ-ний 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн барилга угсралтын ажлын 1 дүгээр гүйцэтгэлээр суурийн ажил, хана хамар ханын ажил, гадна цахилгааны ажил, КТП-ын ажил, гадна бохир усны ажил, гадна гэрэлтүүлгийн ажил, цооногийн ажил, гадна дулааны зэрэг ажлуудад 355.2 сая төгрөгийг ил, далд ажлын актгүйгээр, нотлох баримтгүй,
- Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 30 дугаар цэцэрлэг/ ТАХ-ний барилга угсралтын ажил 3.8 хувьтай байхад захиалагчийн албаны зардлыг төсөвт өртгийн 35.4 хувиар, зохиогчийн хяналтын зардлыг 100 хувиар тооцон 34.1 сая төгрөгийг Барилгын хөгжлийн төвд тус тус олгосон

2.59 Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллага барилга угсралтын ажлын явцад тогтмол, үр дүнтэй хяналт хийдэггүй, хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтээ эргэж шалгадаггүй, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулдаггүй, гэрээг дүгнэдэггүй, гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцдоггүйгээс шалтгаалан хийгдээгүй ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулж, санхүүжилтийг олгосон нь барилга ашиглалтад орох хугацаа удаашрах, хөрөнгө оруулалтын үр ашиг буурах, өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна.

2.60 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.18-д “*Захиалагч барилгын ажлын зардал, ТЭЗҮ, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын*



баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ” заасныг зөрчин нийт 541.6 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардал, зураг төслийн үнийг гүйцэтгэгч компанид шилжүүлжээ.Үүнд:

ЭХС-ын багц:

- “Шинэ хуучин Дарханыг холбосон к14-27 дугаар цэг хүртэлх шугамыг 2Ф600 мм-ийн голчтой 2.6 км дулааны шугамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил /Дархан-Уул, Дархан сум/-ын зохиогчийн хяналтын зардал 39.3 сая төгрөг,
- Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын үнсэн сангийн үнсийг зөөх, дахин ашиглах /Орхон, Баян-Өндөр сум/ ажил зохиогчийн хяналтын зардал 17.6 сая төгрөг,
- Сумын төвийн 0,4 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл/Увс тэс сум/-ийн ажлын зохиогчийн хяналтын зардал 2.3 сая төгрөг, зураг төсвийн зардал 8.5 сая төгрөг,
- Сумын төвийн 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл /Увс, Тариалан сум/-ийн зохиогчийн хяналтын зардал 1.1 сая төгрөг, зураг төсвийн зардал 7.0 сая төгрөг,
- Багийн төвийн эрчим хүчний шугам /Увс Давст сум Хандгайт баг/-ийн зураг төсвийн үнэ 8.0 сая төгрөг.

ЭМС-ын багц:

- Ажлын гүйцэтгэл нь гарсан 18 ТАХ-ний зураг төсвийн үнэ болох 457.8 сая төгрөг.

2.61 БХБС-ын багцад хэрэгжүүлсэн “Нэгдсэн халаалтын зуух, гадна дулааны шинэчлэлт” /Сүхбаатар, Онгон сум/-ийн 1,746.2 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг 2016 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл гүйцэтгэснийг улсын комисс хүлээж аваагүй байхад Барилгын тухай хуулийн 37.6²⁸, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.17²⁹, 6.1³⁰ дэх заалтыг зөрчин үйл ажиллагаа явуулж байна.

2.62 Аудитаар дээр дурдсан 1,746.2 сая төгрөгийн барилга, байгууламжийг улсын комиссыг ажиллуулан байнгын ашиглалтад авах ажлыг зохион байгуулж, зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.

2.63 БСШУСС-ын багц захиалагч болон гүйцэтгэгчийн хамтран тогтоосон магадлашгүй ажлын актгүйгээр 2018 онд гүйцэтгэгч байгууллагад нийт 60.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Тухайлбал,

- Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Өмнөдэлгэр/ ТАХ-ний гүйцэтгэгч “Нью сувагт констракшн” ХХК-д 6.4 сая,
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Дархан, 23 дугаар цэцэрлэг/ ТАХ-ний гүйцэтгэгч “Жинсийн орой” ХХК-д 20.5 сая,
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Төв, Жаргалант/ ТАХ-ний гүйцэтгэгч “Ган цаг” ХХК 13.2 сая,
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний гүйцэтгэгч “Хялганат нуга” ХХК-д 20.8 сая төгрөгийг олгосон байна.

2.64 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.18-д “Захиалагч барилгын ажлын зардал, ТЭЗҮ, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, нормчиллын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ” заасныг зөрчин Бүх нийтийн үүргийн сан улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд Увс аймгийн Зүүнхангай, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын төвд баригдсан нийт 393.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Харилцаа холбооны нэг цэгийн үйлчилгээний төв барих” ажлын санхүүжилтийг олгохдоо гүйцэтгэгч “Хан-Аттрибут” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 36 сарын баталгааны 5 хувь буюу 19.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлээгүй тул албан шаардлага өглөө.

²⁸ Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.

²⁹ Захиалагч шинээр баригдсан барилга байгууламж, их засварыг ашиглалтад оруулах комиссын актаар ашиглалтад хүлээн авна.

³⁰ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.



Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт хангалтгүй байна

2.65 Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр УИХ-ын 2017 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34, 386 дугаар тогтоолыг гаргуулж, тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар Сангийн сайдын 2018 оны 9/3284, 9/7229, 9/3701, 9/393, 9/4390, 9/4377 дугаар албан бичгээр ТЕЗ нарт чиглэл, удирдамж өгч ажилласан байна.

2.66 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 5.3³¹-д заасныг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 19 ТАХ-ний хэрэгжилтийг шалгаж, зөвлөмж, чиглэл өгчээ.

2.67 ТЕЗ нарын Дотоод аудитын нэгж 2018 оны худалдан авах ажиллагааны жилийн тайланд Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.5-д “худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг дотоод аудит /дотоод аудитын нэгжгүй байгууллагын хувьд өөрийн байгууллагын дотоод аудит/-аар хянуулж, холбогдох дүгнэлтийн хамт ирүүлнэ” заасныг үндэслэн шалгалт хийж, дүгнэлт гаргаагүй байна.

2.68 Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.5 дахь заалтыг 2018 оны 281 дүгээр тушаалаар шинэчлэн батлахдаа хассан нь ТЕЗ нарын тайлант оны худалдан авах ажиллагааны тайланд дотоод аудит хийх боломжгүй болгосон байна.

³¹ Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн зарцуулалтын байдалд хяналт тавьж, шаардлагатай бол барилга байгууламж, их засварын ажилд шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна. Үүнд хяналт, шалгалт мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж болно.



БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ БАЙНА

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийгэмд үзүүлэх үр нөлөө, эдийн засгийн үр ашгийг тооцоогүй байна

3.1 Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11-т “Хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үр дүнг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” заасны дагуу баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх үр дүнг тооцох аргачлал байхгүйгээс улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцохгүй явж иржээ.

3.2 Харин Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 295 дугаар тушаалаар дээрх аргачлалыг баталж, 2019 оноос туршин хэрэгжүүлж эхэлсэн байна.

3.3 Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.3-д “ТАХ нь эдийн засгийн хувьд үр ашигтай нь техник, эдийн засгийн үндэслэлээр нотлогдсон байх”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.2-т “Тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь 3.1-т заасан зарчмыг баримталсан байхын зэрэгцээ инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай нь техник эдийн засгийн үндэслэл, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна” заасныг зөрчин улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 83 ТАХ-ний ТЭЗҮ боловсруулагдаагүй байна.

3.4 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-т “Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх” заасныг тус тус зөрчин ХХААХҮС 5.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, Ховд аймгийн Жаргалант суманд “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж”-ийн төслийг 2010 оноос эхлэн хэрэгжүүлэхдээ нийт 1,834.2 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна. Тухайлбал,

- 2010 онд “Арьс ширний үйлдвэр технологийн парк байгуулах төслийн хүрээнд үйлдвэрлэлийн технологийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ боловсруулах” ажлын 240.0 сая төгрөгийн гэрээг “Технологийн хөгжлийн хүрээлэн”-тэй байгуулан зураг төсвийг хийлгэсэн гэх боловч тус зураг төсөв хаана хадгалагдаж байгаа нь тодорхойгүй, дахин ашиглах нөхцөл бүрдээгүй;
- 2010 онд 760.0 сая төгрөгийн санхүүжилттэй “Үйлдвэрлэл технологийн парк байгуулах, арьс ширний үйлдвэрлэлийг дэмжих /Ховд, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар, Баян-Өлгий/” төслийн 4 багц тендерийг зарлаж, аж ахуйн нэгжүүдээс 2 багцад санал ирүүлснийг үнэлж, лагийн байгууламжийн барилга барих ажлын 1 багцын гүйцэтгэгчээр “Мон инж бар” ХК-ийг шалгаруулж, 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 224.2 сая төгрөгийн гэрээ байгуулан төсвийн жил дуусах болсонтой холбогдуулан урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилтийг олгосон боловч тус барилга одоо хүртэл баригдаагүй, гэрээг сунгаагүй, гэрээг дүгнээгүй, олгосон санхүүжилтийн дүнд алданги тооцоогүй;
- Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуулиар төслийн нэрийг “Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж Ховд, Жаргалант” болгон өөрчилж, 3,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,400.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэйгээр баталж, 6 багц болгон тендер зарлаж, 2,712.9 сая төгрөгийн 5 багц ажлыг гүйцэтгүүлэх гэрээг байгуулснаас “Сан” ХХК 1,370.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бэлтгэж, Ховд аймгийн ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байна. Тус тоног төхөөрөмжийг Төрийн өмчийн хорооны 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 455 дугаар тогтоолоор Ховд аймгийн ЗДТГ-ын данс бүртгэлд бүртгэхээр шийдвэр гаргасан боловч одоог хүртэл хэрэгжүүлээгүй, тогтоолын биелэлтийг гаргаагүй нь хөрөнгийн хадгалалт хамгаалалтын горим алдагдах, хөрөнгө эзэнгүйдэх, ашиглалтын шаардлага хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.



3.5 Улсын төсвийн 2012, 2013, 2016, 2017 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад тус ТАХ-ний санхүүжилт батлагдаагүй, 2014, 2015 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан боловч тендер шалгаруулалт хүчингүй болсон зэрэг шалтгаанаар төсөл хэрэгжээгүй зогссон байна.

3.6 Тус төслийг 2018 онд үргэлжлүүлэхээр төсөв батлагдсан тул ТЭЗҮ, зураг төсөв, төсөл боловсруулах, тоног төхөөрөмжид шаардлагатай засвар үйлчилгээ хийх, угсарч суурилуулах, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх зэрэг ажлын даалгаврыг шинээр боловсруулж, тендер зарласан байна.

3.7 Яамны ТНБД-ын 2018 оны А/43 дугаар тушаалаар байгуулсан Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга 2 удаа өөрчлөгдсөн, тендерт оролцогчдоос Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт 2 удаа гомдол гаргаснаас тендер шалгаруулалт удааширч гүйцэтгэгч “Саруул цамхаг” ХХК-тай 4,789.9 сая төгрөгийн 181015/06-393 дугаар гэрээг 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр байгуулж, ажлын гүйцэтгэл 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 14 хувьтай хэрэгжиж байна.

3.8 Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”* заасныг зөрчин 2018 онд тус төслийн тендерийг түлхүүр гардуулах нөхцөлөөр зарлаж, дахин 150.0 сая төгрөгөөр ТЭЗҮ, зураг, төсөв хийлгэсэн байна.

3.9 Тус төслийн хүрээнд 2010 онд “Технологийн хөгжлийн хүрээлэн”-д ТЭЗҮ боловсруулах ажилд олгосон 240.0 сая төгрөг, “Мон инж бар” ХХК-д лагийн байгууламжийн барилга барих ажлын урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгосон 224.2 сая төгрөг, нийт 464.2 сая төгрөгийн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

3.10 Дээрх төслийн санхүүжилтээр 2011 онд худалдан авсан 1,370.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгах талаар Ховд аймгийн Засаг даргад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, бодит үр нөлөөг тооцоогүй байна

3.11 Нийгмийн салбарын нийгэм, эдийн засгийн үр ашгийг БСШУС-ын салбараар төлөөлүүлэн авч үзлээ.

3.12 БСШУСС шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний ТЭЗҮ-ийг боловсруулаагүй, салбарын хэмжээнд ашиглаж байгаа барилга байгууламжийн насжилт, чанар байдлын судалгааг бүрэн хийгээгүй, хүчин чадлыг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тооцсон нэгдсэн судалгаа байхгүйгээс хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг тооцоогүй байна.

3.13 Тус сайдын багцын 2018 онд шинээр барьж эхэлсэн дотуур байр, сургуулийн барилгын хэрэгцээ, шаардлага бодитой эсэхийг тухайн байршилд байгаа барилгын хүчин чадал, насжилт болон сурагчдын тоонд үндэслэн тооцож, дүн шинжилгээ хийж үзэхэд бодит хэрэгцээ, шаардлагад нийцэхгүй төслийг хэрэгжүүлж, ашиглалтын үргүй зардал гарах эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн байна. Тухайлбал,

■ Сургуулийн хичээлийн байрны барилга, өргөтгөлийн хэрэгцээ их байгаа ч бодит хэрэгцээнд үндэслэн тооцоогүйгээр 2018 онд Дундговь аймгийн Дэрэн суманд 320 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга баригдаж байна. Тус сумын сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд нийт 234



сурагч /ахлах ангигүй/ суралцаж байгаа бөгөөд суурь боловсрол эзэмшиж байгаа 98 сурагч /6-9 дүгээр анги/, СӨБ-д хамрагдсан 107 хүүхэд /2-5 насны/ байна.

3.14 Түүврийн аргаар БСШУСС-ын багцын хэрэгжүүлсэн дотуур байрны 5 барилгыг сонгож үзэхэд хэрэгцээ, шаардлагыг бодитой тооцоогүй байна.

Хүснэгт 11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд шинээр барьж байгаа дотуур байрны хүчин чадал, хүүхдийн тооны судалгаа /тоо/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хүчин чадал	Дотуур байрны хүүхдийн тоо /Хичээлийн жилээр/	
			2017-2018	2018-2019
1	Дотуур байрын барилга, 120 ор /Хэнтий, Баян-Овоо сум/	120	30	47
2	Дотуур байрын барилга, 150 ор /Хөвсгөл, Баянзүрх сум/	150	155	135
3	Дотуур байрын барилга, 75 ор /Хөвсгөл, Улаан-Уул сум/	75	130	140
4	Дотуур байрын барилга, 100 ор /Өвөрхангай, Тарагт сум/	100	45	52
5	Дотуур байрын барилга, 150 ор /Хөвсгөл, Түнэл сум/	150	84	89

Эх сурвалж: Тухайн сумын сургуулиас авсан мэдээ

3.15 Хүснэгтээс харахад Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын дотуур байрны барилгаас бусад нь бодитой төлөвлөгдөөгүй байна.

3.16 Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний үр ашгийг тооцож төлөвлөөгүйтэй холбоотой байна.

3.17 Хэрэгцээ, шаардлагатай газарт ТАХ-г хэрэгжүүлсэн нь сайшаалтай боловч шинээр хэрэгжүүлэх төслийн төлөвлөлтөд эрх бүхий албан тушаалтны санал, хүсэлт шууд нөлөөлснөөс улсын төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болох эрсдэлтэй байна.

3.18 БСШУСС-ын багцын 6-аас дээш жил үргэлжлэн хэрэгжиж байгаа ТАХ-ний явцыг судалж үзэхэд анх баталсан хугацаандаа хэрэгжүүлээгүйгээс төсөвт өртөг нэмэгдэж, хөрөнгийн болон цаг хугацааны хувьд үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгджээ.

3.19 Он дамжин хэрэгжиж байгаа ТАХ-ний анх батлагдсан төсөвт өртгийг 2018 оны төсөвт өртгийн өнөөгийн үнэ цэнэтэй³² /Тухайн ТАХ-ний анх батлагдсан дуусах хугацааны үнэ цэнэ/ харьцуулж үзэхэд хугацаанд нь хэрэгжүүлээгүйгээс улсын төсвөөс 35.9 тэрбум төгрөгийн илүү зардал зарцуулахад хүргэсэн байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс үзнэ үү)

3.20 ТАХ-ний хэрэгжилт удаашрахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай нийцүүлж батлаагүй, зарим жилд огт санхүүжилт батлаагүй,
- Зураг, төсөлд ажлын тоо, хэмжээг дутуу тусгаснаар нэмэлт ажил гарсан. Нэмэлт ажлын санхүүжилтийг шийдвэрлэхэд хугацаа шаардаж, явц удааширсан,
- Гүйцэтгэгчийг оновчтой сонгон шалгаруулаагүй.

3.21 БСШУСС-ын багцын 2018 онд тоног төхөөрөмжийн худалдан авалтаас 853.8 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүсэж, арвилан хэмнэлттэй зарцуулсан боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3³³ дахь заалтыг үндэслэн нийт 681.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нэмэлт гэрээгээр, тендерийн хэмнэлтээс 84.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан нь Сангийн сайдын 2016 оны

³² Өнөөгийн үнэ цэнийг Барилга, хот байгуулалтын сайдын жил бүрийн "Барилга угсралтын ажлын үнийн индекс"-ийг ашиглан тооцсон болно.

³³ нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол шууд гэрээ байгуулж болно.



415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.22³⁴ заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 12. Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн худалдан авалтын судалгаа /сая төгрөг/

Хуулийн дугаар	Хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний нэр	Нийт төсөвт өртөг	Гэрээ байгуулсан дүн	Нэмэлт гэрээ байгуулсан дүн	Тендерийн хэмнэлт	Үндэслэл болгосон баримт, бичиг
XIII.5.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж	5,800.0	5,093.9	581.5	124.6	
XIII.1.3.1	Тусгай сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар 25, 70, 186, 116, 63, 55 дугаар сургууль, 10 дугаар цэцэрлэг/	500.0	470.3	0	29.7	БСШУСС-ын 2018.10.30-ны өдрийн А/680 тоот тушаал/
XIII.1.3.2	Тусгай сургуулийн сурагчдын автобус худалдан авах	1,000.0	899.9	100.1	0	
XIII.1.3.4	Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	140.0	122.1	0	17.9	
Нийт		7,440.0	6,586.2	681.6	172.2	84.6

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын тооцоолол

3.22 Энэ нь дээрх журмын заалттай зөрчилдөж байгаа ч нэг талаас батлагдсан төсөвт багтаан худалдан авах ажиллагааны хэмнэлтээс 766.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан нь үр ашигтай харагдах боловч цаашид холбогдох хууль, журмын заалтыг тодорхой, уялдаатай болгох шаардлагатай байна.

3.23 БСШУСС-ын багцын өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа ТАХ-ний төсөвт өртгийн өөрчлөлтийг анх батлагдсан онтой нь харьцуулан үзэхэд олон жил үргэлжилсэн ТАХ-ний төсөвт өртөг үндэслэлгүйгээр нэмэгдсэн байх магадлалтай байна. (Дэлгэрэгүйг хавсралт 5-аас үзнэ үү)

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

3.24 Өмнөх онд хийсэн аудитаар УИХ-ын Төсвийн байнгын хороо, Ерөнхий сайд, Сангийн сайд, Барилга, хот байгуулалт, Зам тээврийн хөгжил, Эрчим хүчний сайд болон Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөрчлийг арилгуулахаар нийт 21 зөвлөмж, 20,744.3 сая төгрөгийн 27 албан шаардлага өгч, зөрчлийг нөхөн төлүүлэхээр 110.2 сая төгрөгийн 6 акт тогтоосныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.25 Өмнөх онуудад хийсэн хөрөнгө оруулалтын аудитаас өгсөн дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, зөрчлүүд давтагдан гарсаар байна.Үүнд:

- Дунд хугацааны хөтөлбөртэй уялдуулаагүй, Засгийн газраас баталсан төсвийн хязгаарыг баримтлаагүй, төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй ТАХ-г саналд тусган өргөн барьсан хэвээр байна.
- Захиалагч ажлын гүйцэтгэлийг зураг, төсөвтэй тулган шалгаж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулдаагүй, ТАХ-г хугацаанд нь ашиглалтад оруулахад шаардлага тавьж ажилладаагүй, зөрчил гаргасан гүйцэтгэгчид хариуцлага тооцдоггүй.
- Ажлын гүйцэтгэлийг бодитой тооцоогүйгээс гүйцэтгээгүй ажилд санхүүжилт олгох, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй.

³⁴ Хөрөнгө оруулалтын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш 6 сарын дараа “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг батлуулсан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хөтөлбөрт үндэслэн төлөвлөсөн гэж үзэх боломжгүй байна.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгагдсан 468.2 тэрбум төгрөгөөр санхүүжих 19 төсөл, арга хэмжээг батлаагүй, төсвийн хязгаараас давуулж 272.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг баталсан нь бодлогын баримт бичгийн уялдаа, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үндэслэл хангагдаагүйг илтгэж байна.
- Төсвийн тухай хуульд тусгагдсан шинээр эхлүүлэх зураг төсөв шаардагдах 423 төсөл, арга хэмжээний 341 буюу 80.6 хувийг хуулийн шаардлага хангаагүй байхад баталсан нь бодлогын баримт бичигт тусгагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээ хэрэгжихгүй байх, улмаар урт болон дунд хугацааны бодлогын зорилт хангагдахгүй байх эрсдэлийг дагуулж байна.
- Засгийн газраас 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг иж бүрэн цахимаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн боловч гүйцэтгэл 49.0 хувьтай байна.
- Сангийн яаманд худалдан авах ажиллагаатай холбоотой 1187 гомдол ирснээс дийлэнх нь тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэх, тендерийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн байхад үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцож ажиллаагүй байна.
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлээр 58 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн, 71 төсөл, төсөл арга хэрэгжээгүйгээс 2018 онд олгохоор баталсан санхүүжилтийн 15.1 хувь буюу 102.9 тэрбум төгрөг зарцуулагдаагүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга, байгууламжийн угсралтын ажлын явцад зохиогчийн хяналт хийх тогтолцоо алдагдсан байна.
- Захиалагчийн хяналтыг гүйцэтгэгч байгууллага барилгын зураг төсвийн дагуу хууль, дүрэмд нийцүүлэн хяналт тавиагүйгээс бодит бус гүйцэтгэлд санхүүжилт олгож, улсад 3.9 тэрбум төгрөгийн хохирол учруулсан байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагч нар барилга, байгууламжийн зураг төсвийн зардлын санхүүжилтийг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэж зураг, төсөв зохиогч компани руу шилжүүлэхгүй ихэвчлэн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч компанид олгосон байна.
- Зарим Төсвийн ерөнхийлөн захирагч нар ажлын гүйцэтгэл гараагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хууль, журмын холбогдох заалтыг зөрчин



нийт 12.4 тэрбум төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг тооцох аргачлал байхгүйгээс тайлант хугацаанд хийгдсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох боломжгүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн, алдаа, зөрчлийг арилгуулахаар Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хариуцлагагүй ажилласан албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- УИХ-аас Монгол Улсын төсвийн тухай хуулийг батлах явцад гишүүдийн саналаар салбарын саналд тусгагдаагүй, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдээгүй, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг батлуулж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд илэрсэн алдаа, зөрчил жил бүр давтагдаж, аудитаар тэдгээрийг арилгуулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг Төсвийн ерөнхийлөн захирагч нар хэрэгжүүлэхгүй байна.

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд илэрсэн алдаа, зөрчил жил бүр давтагдаж, аудитаар тэдгээрийг арилгуулах чиглэлээр өгсөн зөвлөмжийг Төсвийн ерөнхийлөн захирагч нар хэрэгжүүлэхгүй байгаад анхаарал хандуулж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Төсвийн тухай хуульд заасан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан, хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээг батлуулах, худалдан авах ажиллагааг оны эхний хагаст багтаан зохион байгуулах талаар холбогдох, хууль, журамд өөрчлөлт оруулах боломжийг судалж, шийдвэрлүүлэх;

Сангийн сайдад:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааг аргачлалын дагуу сонгож, Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангасан төсөл, арга хэмжээг Засгийн газарт хүргүүлж байх;
- Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг оройтож зарласан, ажил гүйцэтгэх гэрээг барилгын улирал дуусах үед байгуулснаас шалтгаалж урьдчилгаа төлбөрийн баталгаа болон төсвийн ерөнхийлөн захирагч нарын санхүүжилт хүссэн албан бичигт үндэслэн санхүүжилтийг олгох, олгосон санхүүжилтийг барьцаа хөрөнгийн болон техник хяналтын зардлын дансанд байршуулдаг асуудлыг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх;
- Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн ажлын хариуцлагыг сайжруулж, барилга байгууламжийг дутуу орхих, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг арилгах, хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгож, улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг тооцох арга зүйгээр хангаж ажиллах.
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн хяналт хийх зардлын дансыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр үүсгэж, хяналт тавьж ажиллах;



Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- Улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг оновчтой тогтоож, хуулиар тодорхойлогдсон шаардлагыг бүрэн хангасан, эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх үр дүн нь тодорхойлогдсон арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдах төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах;
- Хөрөнгө оруулалтын үе шат бүрд ажлын явц, гүйцэтгэлийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж, ажлын гүйцэтгэлийг тоо хэмжээ бүрээр газар дээр нь хэмжилт хийж баталгаажуулах, ажлын гүйцэтгэлийг зураг, төсөвтэй нь тулган шалгаж, гүйцэтгээгүй ажлыг хийлгэх, баталгаат хугацаанд үүссэн гэмтэл, согогийг засуулах зэрэг арга хэмжээг авах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг анхан шатны баримтаар тулган шалгаж ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд тусгуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах;
- Захиалагч барилга байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэлд зохиогчийн хяналт хийх гэрээг зураг төсөл зохиогч аж ахуйн нэгжтэй байгуулж, барилга угсралтын ажлын үе шат бүрээр дүгнэлт гаргуулан үр дүнг тооцож, санхүүжилтийг олгож байх;
- Улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, чанаргүй барилга, байгууламж барьсан аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар тогтоосон акт, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж, тэдгээрийн биелэлт, үр дүнг тогтоосон хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлэх.



Сангийн яамнаас ирүүлсэн санал




МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.05.31 № 9/3557
танай 2019.06.30-ны № 01/1102-т

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ОЮУНБИЛЭГ
ТАНАА**

Таниас ирүүлсэн 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 01/1102 тоот "Санал авах тухай" албан бичигтэй танилцлаа.

Үндэсний аудитын газраас Монгол Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж тусгах санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА  С.НАРАНЦОГТ



2213



Тайлбар 1-ийг харна уу

Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 5 сарын 21-ний өдрийн 9/559 албан бичгийн хавсралт

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ТУСГАХ САНАЛ, ТАЙЛБАР

1. Тайлангийн төслийн 2.57. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.4-т "Захиалагчийн санхүүжилт хүссэн материалыг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх олгосны дагуу Төсвийн шууд захирагч, эсхүл санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн даргын гарын үсгээр хянан баталгаажуулж, албан тоотгоор Сангийн яаманд хүргүүлнэ", 4.26-д "Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан, эрх шилжүүлж аймаг, нийслэл, сум, дүүрэг худалдан авах ажиллагааг нь зохион байгуулсан төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт, их засварын дансаар дамжиж санхүүжилт нь хийгдэнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч орон нутгаас ирүүлсэн санхүүжилтийн бичиг, баримтыг ажлын 3 хоногийн дотор хянаж, Сангийн яаманд хүргүүлнэ" гэж заасныг зөрчин Сангийн яамнаас эрх шилжүүлсэн төсөв захирагчийн хөрөнгө оруулалтын данс руу санхүүжилтийг шууд шилжүүлжээ. Тухайлбал,

- БХБС-ын багц: Нийт санхүүжилтийн 10.4 хувь буюу 8,389.5 сая төгрөгийг Говь-Алтай, Сэлэнгэ, Сүхбаатар, Говьсүмбэр, Баян-Өлгий, Хэнтий, Орхон, Дундговь, Ховд, Дорноговь, Булган, Дархан-Уул аймгийн эрх шилжүүлэн авсан төсөв захирагч нарт,
- ЭМС-ын багц: Нийт санхүүжилтийн 26.4 хувь буюу 12,271.7 сая төгрөгийг,
- БСШУСС-ын багц: Нийт санхүүжилтийн 36.3 хувь буюу 80.7 тэрбум төгрөгийг.

Тайлбар:

Сангийн сайдын 2017 оны 273 дугаар тушаалаар батлагдсан "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" журмын 4.30, 4.31 дэх заалтын хүрээнд аймаг, нийслэлд хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг орон нутгийн төрийн сангийн хөрөнгө оруулалтын дансанд шилжүүлж байгаа нь зөрчил биш тул дээрх 101.2 тэрбум төгрөгийн зөрчил, дүгнэлтийг тайлангийн төслөөс хасах;

2. Тайлангийн төслийн Ерөнхий мэдээлэл хэсэгт тусгасан "Аудитын явцад 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийг тооцож үзэхэд 73.4 хувь буюу 501.9 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлсэн, 11.5 хувь буюу 78.5 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг гаргаж чадаагүйгээс ТЕЗ нарын санхүүжилт хүссэн албан бичиг болон бодит бус ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулан санхүүжүүлсэн байна.

Тайлбар:

Аудитын явцад 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэлийг тооцож үзэхэд 73.4 хувь буюу 501.9 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлсэн, 11.5 хувь буюу 78.5 тэрбум төгрөгийн ТАХ-ны худалдан авах ажиллагаа оройтож зарлагдсанаас ажил гүйцэтгэх гэрээг барилгын улирал дуусах үед байгуулсан нь тухайн жилд батлагдсан санхүүжилтийг олгох боломжгүй нөхцөл үүссэн байна.

Улмаар орон нутаг, нийгэмд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд эдгээр төслүүдийн санхүүжилтийг арилжааны банкны баталгаанд үндэслэн олгох тухай Засгийн газрын 2018 оны 386 дугаар тогтоол батлагдаж, төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох материалын дагуу олгож тогтоолын хэрэгжилтийг ханган ажилласан тул дүгнэлтийг залруулах;

3. Тайлангийн төслийн ерөнхий мэдээлэл хэсэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр УИХ-ын 2017 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 337 дугаар, 2018 оны 34, 386 дугаар тогтоолыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн тухай болон Сангийн сайдын 2018 оны 9/3284, 9/7229, 9/3701, 9/393, 9/4390, 9/4377 тоот албан бичгээр ТЕЗ нарт чиглэл, удирдамж өгч ажилласан талаар тусгах;

4. Тайлангийн төслийн ТЕЗ нарт өгөх зөвлөмж хэсэгт Сангийн яам, Дэлхийн банкт хамтран Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлуулсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд"-ыг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ашиглах, хэрэгжүүлэх тухай тусгах

Тайлбар 2-ыг харна уу

Тайлбар 3-ыг харна уу

Тайлбар 4-ийг харна уу



Ирүүлсэн саналд өгөх тайлбар

Сангийн яамны ТНБД-ын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 9/3557 дугаар албан бичгээр 2 тайлбар, 2 санал ирүүлсэн байна. Ирүүлсэн саналыг аудитын баг судалж үзээд тайлангийн төсөлд дараах байдлаар тусгалаа.

Тайлбар 1. Саналыг хүлээн авч тайлангийн төслөөс хасав.

Тайлбар 2. Саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлт хийв.

Тайлбар 3. Тайлангийн 2.66-д “Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр УИХ-ын 2017 оны 69 дүгээр тогтоол, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34, 386 дугаар тогтоолыг гаргуулж, тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар Сангийн сайдын 2018 оны 9/3284, 9/7229, 9/3701, 9/393, 9/4390, 9/4377 дугаар албан бичгээр ТЕЗ нарт чиглэл, удирдамж өгч ажилласан байна” гэсэн нэмэлт оруулав.

Тайлбар 4. ТЕЗ нарт өгөх зөвлөмжийн хэсэгт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад тусгагдах төсөл, арга хэмжээг төлөвлөлтөд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах” агуулгаар зөвлөмжийг нэмж оруулав.



ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар төсөвт өртөг нэмэгдсэн шилжих төсөл, арга хэмжээний судалгаа

/сая төгрөг/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсвийн тухай хуульд тусгагдсан төсөвт өртөг		Төсөвт өртгийн зөрүү
			Эхлэх	Дуусах	2018 онд	2017 онд	
1	IV.1.1.1	Аврах гал унтраах ангийн барилга /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	2014	2018	1,820.9	1,250.0	570.9
2	XIII.1.1.1	Дэлхийн зөн Олон улсын байгууллагын тусламжийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2010	2018	14,000.0	8,000.0	6,000.0
3	XIII.1.1.2	Япон Улсын Өвчний үндэс хөтөлбөрийн монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2013	2018	10,700.0	6,200.0	4,500.0
4	XIII.1.1.4	Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга төслийн монголын талын хөрөнгө /Улаанбаатар/	2015	2020	12,900.0	2,300.0	10,600.0
5	XIII.1.1.5	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн монголын талын хөрөнгө /1 цэцэрлэг, 21 сургууль/	2015	2020	5,000.0	1,000.0	4,000.0
6	XIII.1.1.18	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Монгол-Оросын хамтарсан 3 дугаар дунд сургууль/	2016	2018	4,268.2	3,988.5	279.7
7	XIII.1.1.25	Сургуулийн барилга, 640 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэ баг/	2013	2018	4,486.0	4,265.0	221.0
8	XIII.1.1.26	Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Эрдэнэ сум/	2012	2018	2,960.0	2,668.7	291.3
9	XIII.1.1.29	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/	2014	2018	1,439.8	1,250.0	189.8
10	XIII.2.1.5	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2012	2019	9,948.4	9,448.3	500.1
11	XIII.2.1.7	Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилга /Увс, Улаангом сум/	2012	2018	3,406.2	2,995.8	410.4
12	XIII.2.1.8	Соёлын төвийн барилга /Өмнөговь, Манлай сум/	2012	2018	1,381.0	1,200.0	181.0
13	XVI.1.2	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2018	1,351.3	926.3	425.0
14	XVIII.1.2	Сумын эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2015	2018	1,449.0	1,310.0	139.0
15	XVIII.1.5	Сумын эрүүл мэндийн төв, 14 ор /Баянхонгор, Баянцагаан сум/	2013	2018	1,183.5	820.0	363.5
16	XVIII.1.8	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Говь-Алтай, Цээл сум/	2010	2018	1,157.6	1,013.4	144.2
НИЙТ ДҮН					77,451.9	48,636.0	28,815.9



Хавсралт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 онд хэрэгжээгүй төсөл, арга хэмжээний судалгаа

/сая төгрөг/

№	Хуулийн дугаар	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжээгүй шалтгаан					
				Эхлэх	Дуусах			ХАА зохион байгуулагдаагүй	ХАА хүчингүй болсон	ХАА хийгдсэн боловч амжилтгүй	Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь хийгээгүй	Шаардлагагүй арга хэмжээ төлөвлөсөн	Бусад
1	III.2.1.1	Монгол Улсын Ерөнхий сайд	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төслийн монголын талын хөрөнгө	2018	2020	2,752.0	829.5						1
2	IV.1.1.5	Монгол Улсын Шадар сайд	Өвс, тэжээлийн фондын агуулахын барилга худалдан авах /Өмнөговь, Ханхонгор сум/	2018	2018	100.0	100.0					1	
3	V.1.2	ЗГХЭГ-ын дарга	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан, Их-Уул сум/	2013	2018	970.0	750.0		1				
4	VIII.1.1.1	Сангийн сайд	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний монголын талын хөрөнгө /улсын хэмжээнд/	2018	2020	36,874.1	3,900.0						1
5	VIII.3.1.1	Сангийн сайд	Гаалийн газар, хороодын барилгын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/	2018	2019	4,500.0	1,560.0		1				
6	VIII.3.1.3	Сангийн сайд	Гаалийн газрын албан хаагчдын орон сууц /Өмнөговь, Ханбогд сум, Гашуунсухайт боомт/	2018	2018	530.0	530.0		1				
7	X.2.3.1	ХНХС	Ахмадын өргөөний тоног төхөөрөмж /Сүхбаатар, Мөнххаан сум/	2018	2018	30.0	30.0		1				
8	XII.1.4	БХБС	Орон сууцны 14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10 кВТ-ын дэд станцын гаргалгаа 4 иж бүрдэл, 10 кВТ-ын хаалттай хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 10 кВТ-ын хаалттай дэд өртөө 12 иж бүрдэл, 10 кВТ-ын 18.4 км кабель шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	2018	7,137.0	79.5						1
9	XII.1.5	БХБС	Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ø 800-ийн гол шугамыг Ø 1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014	2020	24,949.0	2,000.0						1
10	XII.1.10	БХБС	Дулаан хангамжийн эх үүсвэр, хатуу түлшний халаалтын тогоо 5 ширхэг, ялтсан дулаан солилцуур 3 иж бүрдлийн барилга угсралтын ажил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014	2018	933.8	280.1						1
11	XII.1.11	БХБС	Дулааны шугам сүлжээний Ø 32/200 мм-ийн голчтой 3539 метр шугамын барилга угсралтын ажил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014	2018	942.3	150.0						1
12	XII.1.13	БХБС	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2018	5,000.0	929.7						1
13	XII.1.14	БХБС	Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2013	2018	5,000.0	500.0						1
14	XII.1.28	БХБС	Инженерийн шугам сүлжээ /Орхон, Баян-Өндөр сум, Баянцагаан баг/	2018	2020	3,400.0	1,000.0				1		
15	XII.1.39	БХБС	Ус зайлуулах шугам /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2 дугаар хороо/	2018	2018	20.0	20.0		1				
16	XII.1.40	БХБС	Инженерийн шугам сүлжээний шинэчлэлт /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Орхон хороолол/	2018	2018	1,200.0	1,200.0				1		
17	XII.1.41	БХБС	Хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/	2018	2018	70.0	70.0						1
18	XII.1.43	БХБС	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2018	2019	3,000.0	500.0		1				
19	XIII.1.1.10	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 240 суудал /Булган, Тэшиг сум/	2012	2018	950.0	200.0				1		
20	XIII.1.1.22	БСШУСС	Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Архангай, Хангай сум/	2012	2018	657.2	107.2	1					



Хавсралт 2-ын үргэлжлэл

№	Хуулийн дугаар	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжээгүй шалтгаан					
				Эхлэх	Дуусах			ХАА зохион байгуулагдаагүй	ХАА хүчингүй болсон	ХАА хийгдсэн боловч амжилтгүй	Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь хийгээгүй	Шаардлагагүй арга хэмжээ төлөвлөсөн	Бусад
21	XIII.1.1.31	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/	2012	2018	771.2	93.0						1
22	XIII.1.1.40	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль/	2018	2019	1,500.0	700.0	1					
23	XIII.1.1.48	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Шинэ эхлэл сургууль/	2018	2019	1,500.0	800.0			1			
24	XIII.1.1.49	БСШУСС	Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19 дүгээр сургууль/	2018	2019	3,266.8	1,000.0		1				
25	XIII.1.1.54	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 44 дүгээр сургууль/	2018	2019	2,834.5	1,000.0		1				
26	XIII.1.1.57	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар сургууль/	2018	2019	4,000.0	1,000.0		1				
27	XIII.1.1.77	БСШУСС	Сургуулийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг/	2018	2019	1,000.0	600.0		1				
28	XIII.1.1.82	БСШУСС	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 13 дугаар хороо/	2018	2019	4,000.0	1,996.0	1					
29	XIII.1.1.86	БСШУСС	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 28 дугаар хороо/	2018	2019	5,566.0	2,348.3	1					
30	XIII.1.1.92	БСШУСС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо/	2018	2019	2,840.0	2,340.0		1				
31	XIII.1.1.104	БСШУСС	Дотуур байрын барилга худалдан авах /Өмнөговь, Гурвантэс сум/	2018	2019	2,400.0	1,900.0	1					
32	XIII.1.1.124	БСШУСС	Сургуулийн дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Уулбаян сум/	2018	2019	900.0	200.0		1				
33	XIII.1.1.129	БСШУСС	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 13 дугаар цэцэрлэг/	2018	2019	2,500.0	800.0		1				
34	XIII.1.1.131	БСШУСС	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 66 дугаар цэцэрлэг/	2018	2019	2,500.0	800.0			1			
35	XIII.1.1.134	БСШУСС	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 125 дугаар цэцэрлэг/	2018	2019	2,500.0	800.0		1				
36	XIII.1.1.135	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо/	2018	2019	1,500.0	700.0	1					
37	XIII.1.1.137	БСШУСС	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 280 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/	2018	2019	1,500.0	700.0	1					
38	XIII.1.1.140	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23 дугаар хороо/	2018	2019	1,500.0	700.0	1					
39	XIII.1.1.176	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 21 дүгээр хороо/	2018	2019	2,200.0	1,000.0			1			
40	XIII.1.1.177	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр цэцэрлэг/	2018	2019	1,800.0	900.0			1			
41	XIII.1.1.187	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Бугат сум/	2018	2019	600.0	300.0		1				
42	XIII.1.1.203	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Гандангийн дэнж/	2018	2019	2,000.0	1,000.0	1					
43	XIII.1.1.208	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/	2018	2019	1,500.0	1,000.0	1					
44	XIII.1.1.211	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо/	2018	2019	1,500.0	750.0			1			
45	XIII.2.1.11	БСШУСС	Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2018	8,353.7	1.3						1
46	XIII.2.1.19	БСШУСС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Даваат баг/	2018	2019	1,500.0	850.0		1				



Хавсралт 2-ын үргэлжлэл

№	Хуулийн дугаар	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжээгүй шалтгаан						
				Эхлэх	Дуусах			ХАА зохион байгуулагдаагүй	ХАА хүчингүй болсон	ХАА хийгдсэн боловч амил эхлээгүй	Гүйцэтгэгч ажлаа хугацаанд нь хийгээгүй	Шаардлагагүй арга хэмжээ төлөвлөсөн	Бусад	
47	XIII.2.1.37	БСШУСС	Соёлын төвийн барилга, 200 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	2018	2018	500.0	500.0			1				
48	XIII.3.1.13	БСШУСС	Сагсны талбай /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/	2018	2018	280.0	280.0	1						
49	XIII.3.1.15	БСШУСС	Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2018	2020	4,000.0	500.0	1						
50	XIV.1.1.9	ЗТХС	Дарь-Эх цогцолборын авто замын ажил /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо/	2016	2018	592.0	142.0				1			
51	XIV.1.1.11	ЗТХС	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төслийн монголын талын хөрөнгө /Улаанбаатар/	2018	2020	4,843.6	1,433.5						1	
52	XIV.1.1.12	ЗТХС	Дөмөг захын уулзвараас 6 дугаар хороолол хүртэлх авто замын өргөтгөл, 2.1 км /Орхон, Баян-Өндөр сум/	2018	2019	3,000.0	1,500.0		1					
53	XIV.1.1.19	ЗТХС	Сумын төвийн 8 дугаар багийг 1 дүгээр багтай холбох авто замын нүхэн гарц /Дархан-Уул, Дархан сум/	2018	2019	2,000.0	1,500.0		1					
54	XIV.1.1.23	ЗТХС	Ханын материал орчмын орон сууцны хорооллын доторх хатуу хучилттай авто зам, 0.93 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 6 дугаар хороо/	2018	2018	1,107.2	1,107.2		1					
55	XIV.1.1.33	ЗТХС	Орхон голын гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/	2018	2018	500.0	500.0		1					
56	XIV.1.1.36	ЗТХС	Мандалын голын төмөр бетон гүүр, 62 у/м /Баянхонгор, Галуут сум/	2018	2018	578.7	578.7		1					
57	XIV.1.2.13	ЗТХС	Онон голын төмөр бетон гүүрийн засвар, 238.9 у/м /Хэнтий, Дадал, Баян-Адарга сум/	2018	2019	2,426.1	500.0						1	
58	XIV.1.2.18	ЗТХС	Гашууны голын төмөр бетон гүүрийн их засвар, 72.0 у/м /Увс, Улаангом сум/	2018	2020	2,100.0	500.0		1					
59	XV.1.1	УУХУС	Суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний үлдэгдэл санхүүжилт	2018	2018	143.1	143.1						1	
60	XVI.1.6	ХХААХҮС	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр /Дорнод, Баяндун, Баянтүмэн, Баян-Уул, Хэрлэн, Цагаан-Овоо, Чулуунхороот сум/	2018	2018	500.0	500.0		1					
61	XVI.1.7	ХХААХҮС	Инженерийн хийцтэй гүний худаг /Улаанбаатар, Багануур дүүрэг, 4 дүгээр хороо/	2018	2018	50.0	50.0						1	
62	XVI.1.8	ХХААХҮС	Инженерийн хийцтэй гүний худаг /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 22 дугаар хороо, Тахилт, Хилчин хэсэг/	2018	2018	90.0	90.0		1					
63	XVI.1.9	ХХААХҮС	Инженерийн хийцтэй худаг /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо, Орбит хэсэг/	2018	2018	90.0	90.0				1			
64	XVI.1.10	ХХААХҮС	Зөөврийн болон гүний худаг /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7, 9, 24, 25 дугаар хороо/	2018	2019	1,000.0	600.0						1	
65	XVI.1.12	ХХААХҮС	Инженерийн хийцтэй гүний худаг /Увс, Улаангом сум, 8 дугаар баг/	2018	2018	60.0	60.0		1					
66	XVI.1.20	ХХААХҮС	Ухаалаг худгийн барилга, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо/	2018	2018	300.0	300.0						1	
67	XVI.1.22	ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Дорноговь, Боржигон-эко төсөл/	2018	2019	7,300.0	1,200.0		1					
68	XVIII.1.25	ЭМС	Дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо, Хайлааст салбар/	2018	2019	4,200.0	1,500.0	1						
69	XVIII.1.34	ЭМС	Эрүүл мэндийн төвийн барилга, 150 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9, 10, 14, 16 дугаар хороо/	2018	2019	4,000.0	2,871.8		1					
70	XVIII.1.40	ЭМС	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2018	2020	8,500.0	500.0		1					
71	XVIII.1.42	ЭМС	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2019	2,800.0	1,800.0	1						
ДҮН						212,008.3	57,761.0	14	28	6	5	1	17	



Хавсралт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэрэгжилт дутуу төсөл, арга хэмжээний судалгаа

/сая төгрөг/

№	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжилт дутуу шалтгаан				
				Эхлэх	Дуусах			Гүйцэтгэлийн үйл ажиллагаанаас	Санхүүжилт хугацаандаа олгогдоогүйгээс	Зураг, төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийлгэж хугацаа алдсан	Гадна инженерийн дэд бүтэц шийдэгдээгүйгээс	Гэрээ байгуулсан хугацаанд хэрэгжих боломжгүйгээс
1	III.1.1.1	МҮЕС	Мэдээлэл, харилцаа холбооны нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах /Сүхбаатар аймаг Дарьганга сум/	2013	2018	305.8	103.0	1				
2	XII.1.25	БХБЯ	Орхон аймаг Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн 900 м үерийн хамгаалалтын барилга байгууламж, далангийн барилга угсралтын ажил /Орхон Баян-Өндөр/	2018	2018	429.5	429.5	1				
3	XII.1.18	БХБЯ	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжид 2 дугаар тунгаагуур, 2 ширхэг биоцөөрөм барих ажил	2013	2018	8,519.1	802.0					1
4	XII.1.8	БХБЯ	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, ИШС-ний зураг төслийн ажил/Улаанбаатар/	2018	2018	777.9	777.9	1				
			Сумын төвлөрсөн зуухны БУА /Говь-Алтай, Жаргалан/	2017	2018	796.5	472.0	1				
5	XII.1.9	БХБЯ	Сумын төвийн шинэчлэлт төсөл /Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймагт тус бүр нэг сум/	2014	2018	79,954.0	3,001.0					4
6	XIV.1.1.14	ЗТХС	Гэр бүл, ёслолын ордон хүртэлх авто замын гүүр, авто зогсоол /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2018	2018	300.0	300.0					1
7	XIII.1.1.6	БСШУСС	Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн 2 дугаар байрын барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2018	6,634.9	1,174.5					1
8	XIII.1.1.8	БСШУСС	Сургуулийн барилга, спорт заалын барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум, Эрүүл мэндийн шинжлэх ухааны Их сургуулийн харьяа Анагаах ухааны коллеж/	2013	2018	5,184.7	1,882.0			1		
9	XIII.1.1.23	БСШУСС	Спорт заалын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 61 дүгээр сургууль/	2012	2018	1,599.2	826.8	1				
10	XIII.1.1.29	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Орхон, Баян-Өндөр сум/	2014	2018	1,439.8	184.9					1
11	XIII.1.1.30	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2012	2018	1,287.6	584.1		1			
12	XIII.1.1.31	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/	2012	2018	771.2	93.0	1				
13	XIII.1.1.36	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 62 дугаар сургууль/	2018	2019	3,000.0	900.0					1
14	XIII.1.1.69	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Говь-Алтай, Дарви сум/	2018	2018	1,100.0	1,100.0					1
15	XIII.1.1.71	БСШУСС	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Говь-Алтай, Чандмань сум/	2018	2019	2,200.0	600.0					1
16	XIII.1.1.109	БСШУСС	Дотуур байрын барилга, 150 ор /Баян-Өлгий, Дэлүүн сум/	2018	2018	1,025.0	1,025.0					1
17	XIII.1.1.155	БСШУСС	Цэцэрлэгийн барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2018	2019	1,500.0	750.0					1
18	XIII.1.1.159	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Улаангом сум, 2 дугаар баг/	2018	2019	1,440.0	720.0					1
19	XIII.1.1.162	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Мянгад сум/	2018	2019	1,400.0	500.0					1
20	XIII.1.1.171	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 3 дугаар хороо/	2018	2019	1,100.0	650.0					1
21	XIII.1.1.174	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2018	2018	750.0	750.0					1



Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Хуулийн дугаар	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжилт дутуу шалтгаан					
				Эхлэх	Дуусах			Гүйцэтгэлийн үйл ажиллагаанаас	Санхүүжилт хугацаандаа олгоогүйгээс	Зураг, төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийлгэж хугацаа алдсан	Гадна инженерийн дэд бүтэц шийдэгдээгүйгээс	Гэрээ байгуулсан	Хугацаанд хэрэгжих боломжгүйгээс
22	XIII.1.1.182	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Архангай, Хангай сум/	2018	2018	532.0	532.0	1					
23	XIII.1.1.185	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Төв, Жаргалант сум/	2018	2018	1,000.0	1,000.0						1
24	XIII.1.1.188	БСШУСС	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2018	2019	3,500.0	2,000.0						1
25	XIII.1.1.189	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 15, 16 дугаар хороо/	2018	2019	2,050.0	900.0						1
26	XIII.1.1.190	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 17, 18 дугаар хороо/	2018	2019	2,050.0	900.0						1
27	XIII.1.1.191	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 19, 20 дугаар хороо/	2018	2019	2,050.0	800.0						1
28	XIII.1.1.193	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо/	2018	2019	1,500.0	750.0						1
29	XIII.1.1.194	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	2018	2019	2,200.0	750.0						1
30	XIII.1.1.213	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Сэлэнгэ, Орхонтуул сум, Рашаант тосгон/	2018	2019	870.0	600.0						1
31	XIII.1.1.215	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Эрдэнэ сум/	2018	2018	900.0	900.0						1
32	XIII.1.1.216	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Говь-Алтай, Халиун сум/	2018	2019	900.0	500.0						1
33	XIII.1.1.222	БСШУСС	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/	2018	2019	2,160.0	250.0						1
34	XIII.2.1.23	БСШУСС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Цэцэрлэг сум/	2018	2019	1,500.0	1,000.0						1
35	XIII.2.1.24	БСШУСС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Өлзийт сум/	2018	2019	1,500.0	850.0						1
36	XIII.2.1.25	БСШУСС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Архангай, Хашаат сум/	2018	2019	1,500.0	1,000.0						1
37	XIII.2.1.27	БСШУСС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Өвөрхангай, Бүрд сум/	2018	2019	1,000.0	400.0	1					
38	XIII.2.1.31	БСШУСС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Увс, Зүүнговь сум/	2018	2019	1,500.0	1,000.0						1
39	XVIII.1.1	БСШУСС	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2019	20,000.0	1,700.0	1					
40	XVIII.1.6	БСШУСС	Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд сум/	2011	2018	3,524.4	850.0	1					
41	XVIII.1.11	БСШУСС	Бельгийн Вант Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа Баруун бүсийн эмчилгээ, оношилгооны төвийг сайжруулах төслийн монголын талын хөрөнгө /Ховд, Жаргалант сум/	2013	2019	8,700.0	5,019.1						1
42	XVIII.1.13.1.1	БСШУСС	Багц 1: Гадна ариутгах татуурга, гадна дулаан хангамж, гадна усан хангамжийн ажил	2014	2019	572.1	572.1						1
43	XVIII.1.13.1.2	БСШУСС	Багц 2: Гадна цахилгаан хангамж, гадна холбооны ажил	2014	2019	545.5	545.5	1					
44	XVIII.1.13.2	БСШУСС	Хүчилтөрөгчийн үйлдвэрийн барилгын угсралтын ажил	2014	2019	225.7	225.7	1					
45	XVIII.1.13.3	БСШУСС	Цогцос хадгалах байрны гадна шугам сүлжээний ажил	2014	2019	300.8	300.8						1
46	XVIII.1.14.2	БСШУСС	Өвөрхангай Бүсийн оношилгоо, эмчилгээний төв	2018	2018	350.0	350.0						1
47	XVIII.1.15	БСШУСС	Бүсийн оношилгоо эмчилгээний төвүүдийн ариутгалын тасаг /улсын хэмжээнд/	2018	2019	1,000.0	500.0						1
48	XVIII.1.20	БСШУСС	Төрөх эмнэлгийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Дархан сум/	2018	2019	5,630.4	3,000.0	1					



Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Хуулийн дугаар	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжилт дутуу шалтгаан				
				Эхлэх	Дуусах			Гүйцэтгэлийн үйл ажиллагаанаас	Санхүүжилт хугацаандаа олгоогдоогүйгээс	Зураг, төсөвт өөрчлөлт орж, дахин магадлал хийлгэж хугацаа алдсан	Гадна инженерийн дэд бүтэц шийдэгдээгүйгээс	Гэрээ байгуулсан хугацаанд хэрэгжих боломжгүйгээс
49	XVIII.1.23	БСШУСС	Эмнэлгийн барилга /Баян-Өлгий, Цэнгэл сум, Цохор харгайн нүүдлийн эмнэлэг/	2018	2018	70.0	70.0			1		
50	XVIII.1.24	БСШУСС	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 2 дугаар хороо/	2018	2018	600.0	600.0					1
51	XVIII.1.26	БСШУСС	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Баян-Өлгий, Алтанцөгц сум/	2018	2018	120.0	120.0			1		
52	XVIII.1.31	БСШУСС	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Архангай, Цахир сум/	2018	2019	1,440.0	868.0			1		
53	XVIII.1.32	БСШУСС	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Төв, Заамар сум, Хайлааст баг/	2018	2019	1,500.0	1,000.0					1
54	XVIII.1.33	БСШУСС	Хүүхдийн эмнэлгийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2018	2019	3,316.0	1,040.9					1
55	XVIII.1.35	БСШУСС	Халдварт, сүрьеэгийн эмнэлгийн барилга, 30 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	2018	2019	2,037.6	500.0					1
56	XVIII.1.37	БСШУСС	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Хөвсгөл, Галт сум/	2018	2018	450.0	450.0	1				
57	XVIII.1.38	БСШУСС	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Баян.Өлгий, Өлгий сум/	2018	2020	5,019.7	500.0					1
58	XVIII.1.41	БСШУСС	Зооноз өвчин судлалын үндэсний төвийн агуулахын байрын барилга /Улаанбаат ар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2018	350.0	350.0					1
ДҮН						203,979.6	50,319.8	16	3	4	2	41



Хавсралт 4. Он дамжин хэрэгжсэн ТАХ-ний батлагдсан төсөвт өртгийг 2018 оны төсөвт өртгийн өнөөгийн үнэ цэнэтэй харьцуулсан судалгаа

/сая төгрөг/

Хуулийн дугаар	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	Анх батлагдсан хэрэгжих хугацаа, төсөвт өртөг			2018 оны төсөвт өртгийн өнөөгийн үнэ цэнэ /эхлэх	Өнөөгийн үнэ цэнэ төсөвт өртгийн зөрүү
		Эхлэх	Дуусах		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг		
XIII.1.1.6	Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн 2 дугаар байрын барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2018	6,634.9	2012	2012	900.0	3,847.7	2,947.7
XIII.1.1.9	Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/	2012	2019	5,274.0	2012	2013	3,200.0	4,740.7	1,540.7
XIII.1.1.11	Сургуулийн барилга, 640 суудал /Булган, Булган сум, 1 дүгээр сургууль/	2012	2018	4,300.0	2012	2013	2,000.0	3,865.2	1,865.2
XIII.1.1.12	Сургуулийн барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2012	2018	5,426.9	2012	2013	3,200.0	4,878.1	1,678.1
XIII.1.1.13	Сургуулийн барилга, 640 суудал, /Дорнод, Баян-Уул сум/	2012	2018	3,958.7	2012	2013	1,990.0	3,558.4	1,568.4
XIII.1.1.19	Сургуулийн барилгын комплекс, 320 суудал /Хөвсгөл, Улаан-Уул сум/	2012	2019	3,238.0	2012	2013	1,800.0	2,910.6	1,110.6
XIII.1.1.21	Сургуулийн барилга, 220 суудал /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2014	2018	2,023.5	2014	2014	1,400.0	1,837.1	437.1
XIII.1.1.23	Спорт заалын барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 61 дүгээр сургууль/	2012	2018	1,599.2	2012	2013	550.0	1,437.5	887.5
XIII.1.1.24	Сургуулийн дотуур байрын барилга, 150 ор /Дархан-Уул, Шарын гол сум/	2012	2018	1,502.0	2012	2013	750.0	1,350.1	600.1
XIII.1.1.25	Сургуулийн барилга, 640 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэ баг/	2013	2018	4,486.0	2013	2015	2,200.0	4,154.1	1,954.1
XIII.1.1.26	Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Эрдэнэ сум/	2012	2018	2,960.0	2012	2013	1,800.0	2,660.7	860.7
XIII.2.1.5	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2012	2019	9,948.4	2012	2013	5,100.0	8,942.3	3,842.3
XIII.2.1.6	Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай сум/	2011	2019	9,960.0	2011	2012	3,000.0	5,776.0	2,776.0
XIII.2.1.7	Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилга /Увс, Улаангом сум/	2012	2018	3,406.2	2012	2012	700.0	1,975.3	1,275.3
XIII.2.1.8	Соёлын төвийн барилга /Өмнөговь, Манлай сум/	2012	2018	1,381.0	2012	2013	650.0	1,241.3	591.3
XIII.2.1.10	Соёлын төвийн барилга, 400 суудал /Өвөрхангай, Уянга сум/	2010	2018	1,402.0	2010	2010	450.0	665.9	215.9
XIII.2.1.11	Ханхэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2011	2018	8,353.7	2011	2012	3,500.0	4,844.5	1,344.5
XIII.3.1.1	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2010	2019	9,019.9	2010	2011	2,561.3	4,712.4	2,151.1
XIII.3.1.2	Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2010	2018	8,229.3	2010	2011	2,561.3	4,299.4	1,738.1
XIII.3.1.4	Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2010	2020	10,397.9	2010	2011	1,885.2	5,432.4	3,547.2
XIII.3.1.5	Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/	2010	2020	21,443.0	2011	2012	11,041.0	12,435.2	1,394.2
XIII.3.1.6	Спорт цогцолборын барилга, 500 суудал /Ховд, Манхан сум/	2012	2018	2,458.0	2012	2013	600.0	2,209.4	1,609.4
Нийт дүн				105,487.7			51,838.8	87,774.3	35,935.5



Хавсралт 5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын төсөвт өртөгт орсон өөрчлөлтийн судалгаа

/сая төгрөг/

ТАХ-ний нэр	Онууд									Тайлбар
	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	
Хөдөө аж ахуйн их сургуулийн хичээлийн 2 дугаар байрын барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/			900.0	4,120.0	4,120.0	6,634.9	6,634.9	6,634.9	6,634.9	
Сургуулийн барилга, 960 суудал /Баянхонгор, Баянхонгор сум/			3,200.0	3,200.0	2,906.8	4,693.5	5,654.3	5,654.3	5,274.0	
Сургуулийн барилга, 640 суудал, /Дорнод, Баян-Уул сум/			1,990.0	2,485.0	1,990.0	2,673.6	3,958.7	-	3,958.7	
Сургуулийн барилга, 320 суудал /Төв, Эрдэнэ сум/			1,800.0	1,800.0	1,605.8	2,668.7	2,668.7	2,668.7	2,960.0	2017 онд ашиглалтад орсон.
Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай, Эрдэнэбулган сум/			5,100.0	7,100.0	-	9,448.3	9,448.3	9,448.3	9,948.4	
Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал /Завхан, Улиастай сум/		3,000.0	3,000.0	3,000.0	3,000.0	-	-	-	9,960.0	
Соёлын төвийн барилга, 400 суудал /Өвөрхангай, Уянга сум/	450.0	1,000.0	1,300.0	1,300.0	1,260.0	1,402.0	-	-	1,402.0	
Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2,561.3	2,561.3	2,561.3	9,019.9	9,019.9	-	9,019.9	9,019.9	9,019.9	Ижил хүчин чадалтай ТАХ-ний төсөвт өртөг зөрүүтэй тусгагдсан.
Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2,561.3	2,561.3	2,561.3	8,229.3	8,229.3	-	8,229.3	8,229.3	8,229.3	
Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг/	1,885.2	1,885.2	1,885.2	10,397.9	10,397.9	-	10,397.9	10,397.9	10,397.9	ЧД, БЗД-ийн спорт цогцолбортой харьцуулахад төсөвт өртөг өндөр
Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/	11,014.0	11,014.0	11,014.0	11,014.0	11,014.0	-	21,443.0	21,443.0	21,443.0	
Спорт цогцолборын барилга, 500 суудал /Ховд, Манхан сум/			600.0	600.0	600.0	-	2,118.0	-	2,458.0	2016 онд ашиглалтад орсон. Налайх дүүргийн барилгатай харьцуулахад харьцангуй бага өртөгтэй.
НИЙТ ДҮН	18,471.8	22,021.8	35,911.8	62,266.1	54,143.7	27,521.0	79,573.0	73,496.3	91,686.1	